



“Хөдөө аж аж ахуйн давхар даатгал” ХК

Бизнес төлөвлөгөө 2015-2017

2015 он

Агуулга:

НЭГ.ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

- 1.1 Эдийн засгийн орчны судалгаа.....
 - 1.1.1 2015 оны дэлхийн эдийн засгийн ерөнхий төлөв байдал ба ирээдүйн чиг хандлага
 - 1.1.2 Даатгалын салбарын зах зээлийн судалгаа.....
- 1.2 Макро орчин.....
 - 1.2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн.....
 - 1.2.2 Хэрэглээний үнийн индекс, инфляци.....
- 1.3 Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн эрх зүйн үндэслэл, хуулийн агуулга, ач холбогдол чиг хандлага

ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО

- 2.1 Гүйцэтгэл хураангуй.....
 - 2.1.1 Зорилго зорилт.....
- 2.2 Бизнесийн танилцуулга
- 2.2.1 Бизнес ба түүний түүх
- 2.2.2 Зах зээлийн нөхцөл төлөв байдал
- 2.2.3 Эрхлэх гэж буй даатгалын үйл ажиллагаа түүний хэлбэр.....
- 2.2.4 Даатгалын хураамж.....
- 2.2.5 Нөхөн төлбөр олголт.....
- 2.3 Маркетингийн төлөвлөгөө.....
 - 2.3.1 Зах зээлийн шинжилгээ.....
 - 2.3.2 Маркетингийн стратеги.....
 - 2.3.3 Маркетингийн иж бүрдэл.....
- 2.4 Менежментийн төлөвлөгөө.....
 - 2.4.1 Удирдлага, бүтэц зохион байгуулалт.....
 - 2.4.2 Боловсон хүчин.....
 - 2.4.3 Техник тоног төхөөрөмж, программ хангамж.....
- 2.5 Санхүүгийн төлөвлөгөө.....
 - 2.5.1 Тайлан баланс, үр дүнгийн тооцоо
- 2.6 Эрсдэлийн шинжилгээ.....
 - 2.6.1 Эрсдэлийн төрлүүд.....
 - 2.6.2 Эрсдэлийг багасгах боломжууд.....
- 2.7 Давхар даатгалын төлөвлөгөө.....
- 2.8 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө.....

ГУРАВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН САНАЛ

- 3.1 Олон улсын Банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, олон улсын зөвлөх, санхүүжилт авах чиглэлээр ажиллах.....
- 3.2 Компанийг цаашид үндэсний давхар даатгалын корпораци болоход суурь болох.....


НЭГ.ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

1.1 Эдийн засгийн орчны судалгаа

1.1.1 2015 оны дэлхийн эдийн засгийн ерөнхий төлөв байдал ба ирээдүйн чиг хандлага

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2013 онд бага зэрэг саарч, 3 хувиар өссөн бөгөөд үүнд өндөр хөгжилтэй орнууд төдийгүй, хөгжиж байгаа орнуудын эдийн засаг ч саарав. АНУ-ын Холбооны нөөцийн сан 2012 оны 9 дүгээр сараас эхлэн сар бүр 85 тэрбум ам.долларын бонд худалдан авах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 2013 оны 5 дугаар сард тус нөөцийн сангаас бонд худалдан авах хэмжээгээ багасгахаар мэдэгдсэнээр олон улсын зах зээлд голлох түүхий эдийн үнэ ханш буурч эхэлсэн. Үүнтэй зэрэгцээд дэлхий даяар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 6 хувиар буурав. Дэлхийн эдийн засгийн байдал 2015-2017 онд өмнөх жилүүдээс харьцангуй сайжрах төлөвтэй бөгөөд үүнээс АНУ болон Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2015- 2017 онд бага зэрэг нэмэгдэх хандлагатай байгаа бол БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 7.3-7.4 хувьд хүрч бага зэрэг буурахаар байна.

Зураг 1. Голлох улсуудын эдийн засгийн өсөлтийн таамаглал



Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2014 оноос Евро бүсийн зүгээс санхүүгийн зах зээлийг чадавхижуулах, эдийн засгийн нийт эрэлтийг дэмжих, бүтээгдэхүүний болон хөдөлмөрийн зах зээлийг шинэчлэх, эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгоход чиглэн хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний үр дүнд 1.0 хувиар өсөх хандлагатай байгаа нь дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалд эерэг нөлөөллийг үзүүлэхээр байна. Улмаар Евро бүсийн эдийн засаг 2015 онд 1.4 хувьд хүрч өсөхөөр байна.

Дэлхийн эдийн засаг 2014 онд 3.3 хувийн өсөлттэй гарсан бөгөөд, 2015 онд 3.7 хувийн, 2016 онд 3,9 хувийн өсөлттэй байхаар таамаглаж байна. Энэхүү өсөлтөд үзүүлэх хөгжингүй орнуудын хувь нэмэр харьцангуй өндөр байх төлөвтэй юм.

Хүснэгт 1. Гол түнш орнуудын инфляцийн түвшин

	I.13	II.13	III.13	IV.13	V.13	VI.13	VII.13	VIII.13	IX.13	X.13	XI.13	XII.13	XII.14
БНХАУ	1.9	3.2	2.1	2.4	2.1	2.7	2.7	2.6	3.1	3.2	3.0	2.5	1.5
АНУ	1.6	2.0	1.5	1.1	1.4	1.7	2.0	1.5	1.2	1.0	1.2	1.5	0.7
ОХУ	7.1	7.3	7.0	7.2	7.4	6.9	6.4	6.5	6.1	6.3	6.5	6.5	11.4

Гол түнш орнуудын эдийн засгийн байдал

Хятадын засгийн газар үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбарт дэмжлэг үзүүлж; инфляцийг зорилтот 3.5%-д хүргэх, үйлдвэрлэгчийн инфляцийг нэмэгдүүлэх улмаар хөрөнгө оруулалтын зардал, төрийн өмчийн үйлдвэрүүдийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор мөнгөний бодлогын төлөвийг мөн сулруулсан. Тухайлбал 11 дүгээр сард Хятадын төв банк бодлогын хүүгээ 0.4 нэгж хувиар бууруулж, банк хоорондын захад 35 тэрбум юань нийлүүлсэн. Гэсэн хэдий ч 2014 оны I, II улирлуудад 7.4-7.5%-иар өссөн Хятадын эдийн засаг III, IV улирлуудад 7.3, 7.1%-иар өсч, 2014 оны өсөлт 7.4% буюу зорилтот түвшин (7.5%)-ээс доогуур, инфляци 1.5%-тай гарсан байна. Инфляци ийнхүү зорилтоос хэт доогуур гарсан нь шатахууны үнэ төсөөлж байснаас ихээр унасан бол үүний нөлөөгөөр дотоодын бодит хэрэглээ төдийлөн нэмэгдэхгүй байгаатай холбоотой гэж EIU-ийн судлаачид дүгнэсэн байна. ДНБ-ий өсөлтөд худалдааны ашиг, аж үйлдвэр, эрчим хүчний салбарын өсөлт эерэгээр нөлөөлсөн боловч бизнесийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлт сүүлийн улиралд буурч 13 жилийн хамгийн доод түвшинд буюу жилийн 15.8%- д хүрсэн байна. 2015 оны 1 дүгээр сард импортын зардал жилийн 20 орчим хувиар буурсан нь хэдийгээр шатахуун ба бусад түүхий эдийн үнэ буурсантай холбоотой боловч зэсийн баяжмал, нүүрс, газрын тосны импортын биет хэмжээ мөн буурсан тул үйлдвэрлэгчид цаашид үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээргүй, хуримтлагдсан нөөцөө түлхүү ашиглах төлөвтэй байна гэж EIU- ийн судлаачид дүгнэж байна.

Барууны орнуудын ОХУ-д тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээ, экспортын голлох бүтээгдэхүүн болох газрын тосны үнийн уналтын нөлөөгөөр 2013 онд ОХУ-ын эдийн засаг 1.3%-иар өсч, 6.5%-ийн инфляцитай байсан бол 2014 онд эдийн засаг 0.5%-иар өсч, инфляци 11.4%-д хүрч, рублийн ам.доллартай харьцах ханш 2 дахин суларсан байна. Хориг арга хэмжээний нөлөөгөөр 2014 онд цэврээр 134 тэрбум ам.доллартай тэнцэхүйц хөрөнгө ОХУ-аас гадагшилжээ. 2014 оны эхнээс хөрөнгийн гадагшлах урсгалыг зогсоох зорилгоор ОХУ-ын иргэдийн гадаадад байршуулсан хадгаламжийг татах бодлогын арга хэмжээ авч (санхүүгийн өршөөлийн хүрээнд), Төв банк хүүг 6 удаагийн шийдвэрээр 5.5%-иас 17% хүртэл нэмэгдүүлж, ам.доллар, еврогийн багцтай уясан валютын ханшийн коридорын дэглэмийг зохицуулалттай чөлөөт хөвөгч дэглэмд шилжүүлэн, интервенциэр нийт 80 орчим тэрбум ам.доллартай тэнцэхүйц гадаад валютыг зах зээлд нийлүүлсэн байна. Үүний нөлөөгөөр гадаад валютын нөөц 2014 оны эхэнд 510 тэрбум ам.доллараас 2015 оны 1 дүгээр сард 376 тэрбум болж буурсан байна. 2015 онд худалдааны хориг арга хэмжээг сулруулсан ч ОХУ-ын эдийн засаг 3.5%-иар унаж, төлбөрийн тэнцлийн хүндрэлд орно гэж Roubini ба EIU-ийн судлаачид үзэж байна.

АНУ-ын эдийн засаг 2014 оны II, III улирлуудад голчлон хувийн хөрөнгө оруулалт ба хэрэглээний нөлөөгөөр 4.6%, 5%-иар 18 өссөн боловч IV улиралд хувийн хөрөнгө оруулалт ба цэвэр экспортын өсөлт буурч нийтдээ 2.2%-иар өссөн байна. Оны эхнээс шатахууны үнэ 45%-иар буурсан нь инфляцийг огцом бууруулж 2014 оны эхний хагаст 2.2% байсан инфляци оны эцэст 0.7%-д хүрсэн. Ажил олгогчид 2014 оны сүүлийн 2 сард нийт 752 мянган ажлын байрыг бий болгож, ажилгүйдлийн түвшин 5.6%-д хүрч буурсан, инфляци тогтмол буурсан зэрэг нь өрхийн санхүүг дэмжснээр ДНБ-ий 70%-ийг бүрдүүлэгч хувийн хэрэглээ IV улиралд 4.3%-иар өсч, эдийн засгийн өсөлтөд хамгийн их эерэг нөлөөг үзүүлсэн бол гадаад худалдааны алдагдлын улмаас IV улирлын өсөлт ийнхүү буурсан байна. Тодруулбал, хувийн хэрэглээ өсч, ам.долларын ханш чангарч, гадаад эрэлт төдийлөн сэргэхгүй байгаа нь импортыг нэмэгдүүлж, экспортыг бууруулснаар IV улиралд импорт нь экспортоос 3 дахин хурдан өссөн байна. Ерөнхийдөө АНУ-ын эдийн засаг сайжирч байгаа нь өрхийн хэрэглээг дагаад автомашин, компьютер, тавилга зэргийн худалдан авалт нэмэгдэж, үүнтэй зэрэгцээд ажил олгогчид ажлын байрыг нэмэгдүүлэх буюу хувийн сектор ба хувийн хэрэглээний эерэг хамааралтай холбоотой гэж EIU-ийн судлаачид дүгнэжээ.

1.1.2 Даатгалын салбарын зах зээлийн судалгаа.

Ерөнхий төлөв байдал

2014 онд даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, Хөдөө аж ахуйн давхар даатгалын 1 компани, 247 даатгалын салбар, 3260 даатгалын төлөөлөгч, 30 даатгалын зуучлагч компани, 20 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3342 тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаа явуулсан. Эдгээрээс “Монгол даатгал” ХХК гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, “Ард даатгал” ХХК, “Тан зам даатгал” ХХК-иуд хамтарсан хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар 2013 оны мөн үеийнхээс 1.03 дахин нэмэгдсэн байна.

Зураг 2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо



Даатгагчийн хөрөнгө: 2014 оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 152.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх 2013 оны мөн үетэй харьцуулахад 26.1 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилд 2.7 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгийн хэмжээ 30.4 хувийг эзэлж байна.

Зураг 3. Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ./тэрбум төгрөгөөр/



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2014 оны 4 дүгээр улиралд 125.7 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 82.41 хувь, эргэлтийн бус хөрөнгө 26.8 тэрбум төгрөг буюу 17.59 хувийг эзэлж байгаа бол 2013 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 109.5 тэрбум төгрөг буюу 82.5 хувийг эзэлж, эргэлтийн бус хөрөнгө 16.8 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө.


Үзүүлэлтүүд	Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө				/сая төгрөгөөр/	
	2013.12.31		2014.12.31		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	109583,3	82,5	125695,6	82,41	16112,30	1.80
Эргэлтийн бус хөрөнгө	16819,9	17,5	26827,3	17,59	10007,40	/1.80/
Нийт хөрөнгө	126403,2	100	152522,9	100	26119,70	

2014 оны жилийн эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн 60.1 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 20.8 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 16.5 хувийг дансны авлага, үлдэх 2.58 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад эргэлтийн хөрөнгө 0,18 пунктээр, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 8.16 пунктээр тус тус буурч, дансны авлага 1.43 пунктээр, богино хугацаат хөрөнгө оруулалт 6.9 пунктээр тус тус өссөн байна. Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс

16,112.3 сая төгрөгөөр өссөн нь даатгалын компаниуд дүрмийн сангаа 3.5 тэрбум төгрөгт хүргэж, хувьцаат капиталын дүнгээ нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч: Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилийн оны эцсийн байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна.

Зураг 4. Өр төлбөр эзэмшигчийн өмч, нөөц сангийн харьцаа



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2010 оны 4 дүгээр улиралд 51.4 хувийг эзэлж байсан бол 2011 оны 4 дүгээр улиралд 44.5 хувь, 2012 оны 4 дүгээр улиралд 44.8 хувь, 2013 оны мөн үед 46.5 хувь эзэлж, тайлант онд 43.3 хувь эзэлж байгаагаас харвал даатгалын компаниудын нөөц сан сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Энэ нь компаниуд ашигтай ажиллаж, дүрмийн сангаа нэмэгдүүлэх хүсэлтэй болсонтой холбоотой болно.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2010 оноос хойш тогтвортой өсч ирсэн байна. Харин өр төлбөрийн дүн өмнөх онд 5.0 хувь байсан бол тайлант онд 7.64 хувь болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 3.Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө.

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө					/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт	2013		2014		Өөрчлөлт	
	Сая/төг	хувь	Сая/төг	хувь	Сая/төг	пункт
Өр төлбөр	6 320.40	5.00	11 658.7	7.64	5 338.30	2.64
Нөөц сан	58 769.80	46.49	66 113.60	43.35	7 343.80	3.15
Эзэмшигчийн өмч	61 313.10	48.51	74 750.60	49.01	13 437.50	0.50
Нийт дүн	126403,2	100	15 2522.9	100	26119.60	


Тайлант үеийн эзэмшигчдийн өмчийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар тогтвортой өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж ирсэн нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй холбоотой байна.

Даатгалын хураамжийн орлого: Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2014 оны эцэст 108,746.7 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16 хувиар өссөн байна. Ердийн даатгалын компаниуд 107,305.6 сая төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 1441.1 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна. Ердийн даатгалын компанийн даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 42015.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Даатгалын компаниудын хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2014 оны 4 дүгээр улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 11 хувь, хөрөнгийн даатгал 26 хувь, автотээврийн хэрэгслийн даатгал 12 хувь, ачааны даатгал 76 хувь, санхүүгийн даатгал 26 хувь, мал амьтадын даатгал 16 хувь, жолоочийн хариуцлагын даатгал 65 хувь, эрүүл мэндийн даатгал 2.08 дахин, тэтгэврийн даатгал 0,7 хувь тус тус өсч, барилга угсралтын даатгал 65.0 хувиар, агаарын хөлгийн даатгал 16.0 хувиар, хуримтлалын даатгал 3.0 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 4. Даатгалын хураамжийн орлого


Даатгалын хэлбэр	2013.12.31	2014.12.31	Өөрчлөлт /+,/-/
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	9 107.1	10 125.80	1.11
1.2 Хөрөнгийн даатгал	25 628.00	32 266.80	1.26
1.3 Авто тээврийн хэрэгслийн даатгал	16 332.70	18 277.60	1.12
1.4 Ачааны даатгал	1 810.20	3 190.20	1.76
1.5 Барилга угсралтын даатгал	4 122.20	1 433.70	0.35
1.6 Газар тариалангийн даатгал			
1.7 Мал амьтдын даатгал	770.80	890.30	1.16
1.8 Агаарын хөлгийн даатгал	7 044.4	6 461.90	0.92
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	3 295.40	424.30	
1.10 Хариуцлагын даатгал	7 069.80	5 912.00	0.84
1.11 Санхүүгийн даатгал	2 576.80	3 259.50	1.26
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	12 230.10	20 088.80	1.64
1.13 Зээлийн даатгал	2 191.70	2 707.60	
1.14 Итгэлцлийн даатгал	6.60	61.70	
1.15 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	686.00	2 205.40	
2.1 Хугацаат амьдарлын даатгал	379.30	269.80	0.97
2.2 Хуримтлалын даатгал	103.70	100.60	1.07
2.3 Тэтгэврийн даатгал	57.90	62.10	2.08
2.4 Эрүүл мэндийн даатгал	484.70	1008.60	1.16
Нийт	93 897.40	108 746.70	

Зураг 5. Даатгалын хураамжийн орлого



2005 оноос хойш 2014 он хүртэл нийт орлогын өсөлт 99.21 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн нь 2012 оноос “Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бөгөөд албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, даатгалын хураамжийн орлогыг сүүлийн жилийн дундажаас илүү өссөн байна. Түүнчлэн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан байна. Даатгалын хураамжийн орлогын өсөлтөд мөн инфляци, үнийн өсөлтүүд нөлөөлсөн гэж үзэж болно.

Зураг 6. Нөхөн төлбөр, хураамжын орлого.



Даатгалын нийт хураамжийн орлогыг ДНБ-д эзлэх хувиар харуулахад өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.03 пунктээр буурсан байна.


Даатгалын нөхөн төлбөр: 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 31481.1 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон. Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн олгосон даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 39.2 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.5 дахин, хөрөнгийн даатгал 1.3 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.08 дахин, агаарын хөлгийн даатгал 12.3, хариуцлагын даатгал 1.91 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 2.2 дахин, зээлийн даатгал 1.75 дахин, хугацаат амьдралын даатгал 1.26 дахин, хуримтлалын даатгал 5.72, дахин, тэтгэврийн даатгал 3.38 дахин тус тус, хөрөнгийн даатгал 10.0 хувиар, ачааны даатгал 32.0 хувиар, барилга угсралтын даатгал 22.0 хувь, мал амьтдын даатгал 66.0 хувиар, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 93.0 хувиар, санхүүгийн даатгал 29.0 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 5. Даатгалын хураамжийн орлого. /бүтээгдэхүүнээр/

Даатгалын хэлбэр	2013.12.31	2014.12.31	Өөрчлөлт +/, -/
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2 155.50	10 125.80	1.50
1.2 Хөрөнгийн даатгал	2 377.30	2 146.40	0.90
1.3 Авто тээврийн хэрэгслийн даатгал	7 442.90	8 021.60	1.08
1.4 Ачааны даатгал	260.20	175.70	0.68
1.5 Барилга угсралтын даатгал	79.80	62.50	0.78
1.6 Газар тариалангийн даатгал			
1.7 Мал амьтдын даатгал	57.70	19.90	0.34
1.8 Агаарын хөлгийн даатгал	7.70	94.70	12.30
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	2 309.20	172.90	0.07
1.10 Хариуцлагын даатгал	315.80	604.50	1.91
1.11 Санхүүгийн даатгал	911.10	648.30	0.71
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	8 350.70	12 292.20	1.47
1.13 Зээлийн даатгал	1 932.10	3 386.70	1.75
1.14 Итгэлцлийн даатгал			
1.15 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		6.90	
2.1 Хугацаат амьдралын даатгал	52.00	71.70	1.38
2.2 Хуримтлалын даатгал	78.40	99.00	1.26
2.3 Тэтгэврийн даатгал	6.00	34.30	5.72
2.4 Эрүүл мэндийн даатгал	122.90	415.40	3.38
Нийт дүн	26 459.30	31 481.10	1.19

2014 онд даатгагчийн нөхөн төлбөр 31.5 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 10 жилийн өмнөх 13.3 дахин өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэ үзүүлэлтээс харахад нөхөн төлбөр тогтмол өссөн үзүүлэлт ажиглагдаж байна.

Зураг 7. Даатгалын нөхөн төлбөр



Даатгагчийн ашигт ажиллагаа: 2014 оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 2027.5 сая төгрөг байна.

Зураг 8. Хуримтлагдсан ашиг (алдагдал) сая төгрөгөөр



Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг тайлант онд өмнөх оны мөн үеийнхээс 2996.1 сая төгрөгөөр буурсан нь дүрмийн сангаа хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж байгаатай

холбоотой юм. Мөн алдагдалтай ажиллаж байгаа компаниудын хуримтлагдсан алдагдал нөлөөлж байна.


Даатгалын нөөц сан: Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2010 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 29.1 тэрбум төгрөг байсан бол 2014 оны эцэст 66.1 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 2.3 дахин нэмэгдсэн байна.

Зураг 9. Даатгалын нөөц сан.



Давхар даатгал: 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 31.6 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн дүнтэй гарсан байна.


Зураг 10. Давхар даатгалын хураамж.



Тайлант оны жилийн эцсийн байдлаар гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2013 оны мөн үеийнхтэй харьцуулахад давхар даатгалын хураамжийн хэмжээгээ “Ард даатгал” ХХК 2417.5, “Миг даатгал” ХХК 1115.8, “Моннис даатгал” ХХК 250.7, “Нэйшнл лайф даатгал” ХХК 43.0, “Тэнгэр даатгал” ХХК 2051.6 сая төгрөгөөр тус тус гадаадын давхар даатгалд төлсөн хураамжаа бууруулж, “Практикал даатгал” ХХК 38.7, “Монгол даатгал” ХХК 4195.2, “Номин даатгал” ХХК 142.0, “Мандал женерал даатгал” ХХК 681.3, “Хаан даатгал” ХХК 129.2, “Монре даатгал” ХХК 89.4, “Бодь даатгал” ХХК 6127.8, “Соёмбо даатгал” ХХК 72.9 сая төгрөгөөр тус тус давхар даатгалын хураамжийг нэмэгдүүлсэн байна. 2014 онд даатгалын компаниуд өөрсдийн хүлээсэн эрсдэлээ гадаадын давхар даатгагчид даатгуулах хандлага өсч өмнөх оны мөн үеийнхээс 1.21 дахин нэмэгдсэн байна.

Урт хугацааны даатгалын хөрөнгө, эзэмшигчийн өмч: Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 5362.2 сая төгрөгөөр буюу 5.7 дахин нэмэгдсэн байна.

Зураг 11. Нийт хөрөнгө



Урт хугацааны даатгалын орлого, давхар даатгал: Урт хугацааны даатгалын компани 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар 1441.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 21.6 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 259.3 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад даатгалын хураамжийн орлого 1.4 дахин, нөхөн төлбөр 2.4 дахин нэмэгдэж, давхар даатгал 2.9 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. Урт хугацааны даатгалын орлого, давхар даатгал, нөхөн төлбөр.

Он	2009	2010	2011	2012	2013	2014
Хураамжийн орлого	115.3	285.2	510.3	795.6	1025.6	1441.0
Давхар даатгал		107.0	94.7	44.7	64.6	21.6
Нөхөн төлбөр		45.7	69.9	199.3	259.3	635.4

Тус компанийн даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр 2010 оноос тогтмол нэмэгджээ.

Зураг 12. Хураамж, давхар даатгал



Давхар даатгал:

Даатгалын компани нь өөрийн хүчин чадлаас хэтэрсэн хэмжээний хариуцлага эрсдэлийг даатгасан тохиолдолд энэ эрсдэлээ багасгах зайлшгүй шаардлагатай болдог. Иймд даатгалын компани өөрийн эрсдэлийн зарим хэсгийг дахин өөр компанид даатгуулдаг. Энэ үйл ажиллагааг давхар даатгал гэж нэрлэдэг. Давхар даатгалын үндсэн зорилго нь даатгуулагчийн өмнө хүлээх үүргээ баталгаажуулж байгаа хэрэг юм. Даатгалын үндсэн баримт бичиг нь даатгалын гэрээт баталгаа байдаг бол давхар даатгалын хувьд энэ баримт нь давхар даатгалын гэрээ байдаг. Энэ гэрээнд давхар даатгагч даатгуулагчийн нэр хаяг даатгалын зүйлийн талаарх мэдээлэл даатгалын хугацаа эрсдэл зарим хасалтууд үнэлгээ анхны даатгагчид ноогдох шимтгэл зэрэг мэдээллийг тусгасан байдаг.

Далайн давхар даатгал 17,18-р зуунд үүссэн бөгөөд Европт үйлдвэрлэл худалдаа эрчимтэй хөгжиж эхлэсэн 19-р зуунд давхар даатгал өргөжин хөгжиж, мэргэжлийн давхар даатгалын компаниуд бий болж эхэлжээ. Германд 1846 онд хамгийн анхны давхар даатгалын компани Gologne re, Швейцарт 1863 онд Swiss Re, 1880 онд Munich Re зэрэг компаниуд байгуулагдсан. Өнөөгийн байдлаар дэлхийд хэдэн мянган давхар даатгагч нар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тэднийг ерөнхийд нь хуваавал:

- Үндэсний давхар даатгалын компанын компаниуд. Дэлхийн 2-р дайны дараа НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлаас хөгжиж байгаа орнуудын гадны даатгагч нараас хэт хараат байдлыг багасгахын тулд өөрийн орны үндэсний даатгалын компани байгуулахыг зөвлөсний дагуу төрийн өмчийн даатгалын компаниудыг байгуулсан. Улсын давхар даатгалын байгууллага нь дотооддоо давхар даатгалыг хийх замаар валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, гадагшаа валют урсахыг багасгах зорилготой байсан. Үүний нэг жишээ бол:

Солонгосын Korean Re юм. Анх төрийн өмчийн хэлбэрээр дээрх зорилгоор байгуулагдсан бөгөөд сүүлд хувьчлагдсан байна.

- Мэргэжлийн давхар даагч нар. Үүнд дээр дурдсан Swiss Re, Menich Re зэрэг орно. Эдгээр нь дэлхий даяар таран байрлсан өөрсдийн төлөөлөгчдөөрөө дамжуулан дэлхийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг.
- Ллойдын синдикатууд. Эдгээр нь даатгал, давхар даатгалыг хэдэн зууны турш хийж ирсэн их туршлагатай. Синдикатын гишүүн бүр нь хязгааргүй хариуцлага хүлээдэг.
- Агентлагууд. Орон тооны бус давхар даатгалын агентууд нь ихэвчлэн брокеруудаар дамжуулан давхар даатгал хийдэг.
- POOL; улсын болон монополь компаниудын хувьд өөрсдийн эрсдэлийг багасгах зорилгоор орон нутгийн чанартай дундын POOL байгуулдаг.
- Каптив компаниуд олон том үйлдвэрлэгч болон худалдааны компаниуд өөрийн хажууд өөрийнхөө эрсдэлийг даатгах даатгалын компаниудыг байгуулдаг. Эдгээр компаниуд нь үйл ажиллагаагаа өргөжүүлж чөлөөт зах зээл дээр даатгал, давхар даатгал хийж эхэлдэг. Энэ нь ихэвчлэн толгой компаниуддаа татварын диваажинг бий болгох зорилгоор байгуулагдсан байдаг.

Монгол улсын Давхар даатгал:

Монголын даатгалын томоохон компаниуд дэлхийд нэр хүндтэй брокеруудаар дамжуулан, томоохон давхар даагчид, Ллойдийн синдикатууд зэрэг нийт 70 шахам компаниудтай давхар даатгалын чиглэлээр хамтран ажиллаж байна. Манай улс иргэний агаарын хөлөг, түүнийг эзэмшигчийн хариуцлага, нисэх бүрэлдэхүүний эрүүл мэнд, гэнэтийн осол, үйлдвэрийн болон үйлдвэрийн бус барилга байгууламж, электрон тоног төхөөрөмж, уул уурхайн хүнд тоног төхөөрөмж, барилга угсралт, газрын тос, нефть бүтээгдэхүүн, жуулчдын эрүүл мэнд, гэнэтийн ослын томоохон эрсдэлүүдийг даатгалын брокер, давхар даагч нарт давхар даатгаж байна.

Асимон Брокерс компани давхар даатгалын чиглэлээр Монгол улсад хамгийн туршлагатай компани юм. Монгол улсын бусад даатгалын компаниудтай хамтран ажиллаж, олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн давхар даатгалын зуучлалын үйлчилгээгээр хангадаг бөгөөд үйлчлүүлэгчдийнхээ эд хөрөнгийн, хариуцлагын, хохирлын болон бусад төрлийн эрсдэлүүдийг дэлхийд тэргүүлэгч Munich Re, Hannover Re, Korean Re, Lloyd's, Ingosstrakh Ltd зэрэг компаниудад давхар даатгаж, шууд болон тэдний түншлэгч олон улсын давхар даатгалын брокеруудаар дамжуулан даатгадаг.

1.2 Макро орчин


1.2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай улсын эдийн засгийн өсөлт 7.8 хувьд хүрлээ. Энэхүү өсөлтөд малын тоо 52 сая толгойд хүрч, манай орны эдийн засгийн уламжлалт салбар болох хөдөө аж ахуйн салбар 14.4 хувиар өссөн, экспортын голлох бүтээгдэхүүнүүдээс зэсийн баяжмал, газрын тосны олборлолт, экспортын хэмжээ огцом өсч, 2014 онд 1.4 сая тонн зэсийн баяжмал, 6.9 сая тонн газрын тос экспортолсон нь уул уурхайн салбарт өндөр өсөлт гарахад голлон нөлөөлжээ. 2011 онд 17.3 хувиар өсч байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурдац ийнхүү саарахад экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ унасан, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурсан нь нөлөөлөв. Эдийн засгийн өсөлтийн хурдац саарч, бизнесийн идэвхжил суларч байгаагаас 2014 онд худалдааны салбар 6.9 хувийн уналттай гарлаа.

Хүснэгт 7.

	2011 I-IV	2012 I-IV	2013 I-IV	2014 I-IV
Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, хувь	17.3	12.3	11.6	7.8
ХАА-н салбарын өсөлт, хувь	-0.3	21.1	19.3	14.4
Аж үйлдвэр, барилгын салбарын өсөлт, хувь	8.8	14.8	15.3	4.8
Үйлчилгээний салбарын өсөлт, хувь	17.8	10.3	6.8	4.8
ДНБ-ий хэмжээ, оны үнээр, тэрбум төгрөг	13,174	16,668	19,118	21,844


Зураг 13. Төсвийн орлого, зарлагын хэмжээ



ДНБ-ий 2015 оны зорилт, 2016-2017 оны хандлага

Дэлхийн болон худалдааны гол түнш орнуудын эдийн засгийн төлөв байдал, дотоод орчны нөхцөл байдлыг харгалзан үзэж, 2015 онд хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалахыг зорьж байна.

Зураг 14. ДНБ-ий хэмжээ /их наяд төг/, ЭЗ-ийн бодит өсөлт /хувиар/




ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь.

Хөдөө аж ахуйн салбар 2014 онд өмнөх оноос 14.4 хувиар өслөө. Мал аж ахуйн салбарын хувьд 2014 оны эцсээр улсын хэмжээнд нийт 52.0 гаруй сая толгой мал тоологдсон нь өмнөх оноос 15.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Тухайн онд нийт 17.5 сая толгой мал буюу нийт төллөх хээлтэгч малын 90.1 хувь нь төллөсөн бөгөөд төл малын бойжилтын хувь өмнөх оноос 1.5 нэгж хувиар өндөр буюу 97.8 хувьтай байжээ. Зүй бусаар 401.4 мянган толгой том мал хорогдсон нь оны эхэнд тоологдсон нийт малын 0.9 хувь болж байна. Газар тариалангийн салбарын хувьд 2014 оны ургац хураалтаар улсын хэмжээнд нийтдээ 518.8 мянган тонн үр тариа, үүнээс 488.3 мянган тонн улаан буудай (өмнөх оноос 32.5% өсөлттэй), 161.5 мянган тонн төмс (өмнөх оноос 15.7% бууралттай), 104.8 мянган тонн хүнсний ногоо (өмнөх оноос 3.0% өсөлттэй) хураан авчээ.

Зураг 15. Дотоодын нийт бүтээгдэхүүн



Зураг 16. ДНБ-нд Хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь




Хүснэгт 8. Хөдөө аж ахуйн салбар.

Үзүүлэлт	2011	2012	2013	2014
ДНБ, тэрбум төг	13 173.8	16 688.4	19 118.0	21 844.0
Хөдөө аж ахуй, ой, загас, ан агнуурын аж ахуй	1 357.9	1 878.8	2 603.6	3 749.1
Мал аж ахуй	1 238.8	1 701.7	2321.5	
Газар тариалан	98.3	137.3	275.8	
Ой, загас, ан агнуурын аж ахуй	20.9	39.8	6.3	
Улсын төсвийн зарлагад ХАА-н салбарын эзлэх хувь	5	3.7	3	

Сүүлийн жилүүдэд ХАА-н салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2 дахин нэмэгдсэн хэдийч ДНБ-д ХАА-н салбарын эзлэх хувийн жин буурсаар байгаа нь Уул уурхайн салбарын өсөлттэй холбоотой.

Олон улсын туршлагаас харахад өндөр хөгжилтэй орны даатгалын салбар санхүүгийн салбартаа эзлэх хувь өндөр байдаг. Дараахи хүснэгтэнд даатгалын салбарын ДНБ-д эзлэх хувийг харуулав.


Зураг 17. Өндөр хөгжилтэй орнуудын даатгалын салбар, санхүүгийн салбартаа эзлэх хувь.



1.2.2 Хэрэглээний үнийн индекс, инфляци

Инфляци 2014 оны эцэст 11.0% хүрч, 2015 оны эцэст 9.5% гарахаар төсөөлөгдөж байна. 2014 оны эхнээс үйлдвэрлэлийн зөрүү сөрөг болж, үйлдвэрлэлийн өсөлт саарч байгаа нь инфляцийг бууруулах чиглэлд нөлөөлөхөөр байгаа ч, төлбөрийн тэнцэлд 2012 оноос үүссэн дарамт нь 2013 онд хямралын шинжтэй болж, Монгол Улсын гадаад цэвэр актив сүүлийн 20 сарын хугацаанд 5.3 их наяд төгрөгөөр огцом буурсны зэрэгцээ төсвөөс гадуурх зарцуулалтыг оруулж тооцсон төсвийн алдагдал өндөр хэвээр байгаа нь инфляцид сөргөөр нөлөөлж байна. 2015 онд эрэлтийн гаралтай инфляцийн дарамт бага байх төлөвтэй хэдий ч, гадаад валютын орох урсгал нэмэгдэхгүй, төлбөрийн тэнцэл ихээхэн алдагдалтай, макро эдийн засгийн гадаад тэнцвэр сайжрахгүй байгаагаас үзэхэд суурь инфляци өсч, инфляцийн дарамт төдийлөн буурахгүй байж болзошгүй байна.

Зураг 18. Инфляци, эдийн засгийн бодит өсөлт.



Эдийн засгийн өсөлт 2014 онд саарч нэг оронтой тоонд орлоо. Эдийн засаг 2014 оны 4 дүгээр улиралд өмнө онтой харьцуулахад 9.1 хувиар тэлж 2014 оны ДНБ-ий өсөлт 7.8 хувь боллоо. Эрэлт талаас эдийн засгийн өсөлт нэмэгдэхэд өрхийн хэрэглээ, гадаад худалдаа голлох нөлөөг үзүүлсэн бол хөрөнгө оруулалт буурч өсөлтийг сааруулав. Үйлдвэрлэл талаас уул уурхай, хөдөө аж ахуй, тээвэр агуулахын салбарууд өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж, худалдаа болон бүтээгдэхүүний цэвэр татвар өсөлтийг бууруулах нөлөөг үзүүллээ. Потенциал ДНБ-ий өсөлт 2012 оны дунд үеэс буурах хандлагатай байгаа бөгөөд 2014 оны сүүлийн улиралд 6-8% орчим байна. Гадаад эрэлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 оноос хойш муудаж эхэлсэн тул дотоод эдийн засгийн идэвхжил суларч, потенциал үйлдвэрлэлийн өсөлт ийнхүү саарчээ. Бодит ДНБ потенциал түвшнээс сүүлийн 3 улирлын турш доогуур байсан боловч уул уурхайн салбарын нөлөөгөөр 2014 оны эцэст зөрүү арилж, үйлдвэрлэлийн зөрүү бараг тэг түвшинд ирэхээр байна.

Хэрэглээний үнэ 2014 онд улсын хэмжээнд 11.0 хувиар, Улаанбаатар хотын хэмжээнд 10.7 хувиар өссөн нь инфляцийн зорилтот түвшнээс 3 орчим нэгж хувиар өндөр үзүүлэлт юм. Төлбөрийн тэнцлийн хүндрэлийн улмаас 2013 оны 7 дугаар сараас эхлэн төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом суларсан нь хэрэглээний үнийг, түүний дотор импортын бараа болон “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр” (ҮТХ)-т хамрагдаагүй дотоодын бусад барааны үнийг нэмэгдүүлж байв. 2014 оны сүүлийн хагаст уг өндөр өсөлтийн нөлөө арилж инфляцийн түвшин буурсаар байна. Хэрэглээний сагсны хамгийн их үнийн хэлбэлзэлтэй бүтээгдэхүүн байсан махны үнийн өсөлт огцом буурч жилийн инфляци буурахад эерэг нөлөө үзүүлсэн. Тэгвэл хүнс, шатахуун, төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийн улмаас нэмэгдэж, инфляцид илүү нөлөөлөх болов.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлд ХҮИ-ээр хэмжсэн инфляцийг 2014 оны эцэст 8 хувь, 2015-2016 оны эцэст 7 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан билээ. 2014 оны эцэст жилийн суурь инфляци улсын хэмжээнд 11.0 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 10.7 хувь гарсан нь инфляцийн зорилтот түвшнээс 3 орчим нэгж хувиар өндөр үзүүлэлт юм. Инфляци зорилтоосоо өндөр гарсан нь: 1) Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2014 онд 13.8 хувиар суларч, импортын хэрэглээний барааны үнэ 11.1 хувиар өссөн, 2) Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ 2014 онд жилийн инфляцийг 1.58 нэгж хувиар нэмэгдүүлэв. Эдгээр нь өмнөх онуудаас илүү хүчтэй нөлөөлсөн бөгөөд мөнгөний бодлогоор шууд нөлөө үзүүлэх боломжгүй байлаа.

Зураг 19. Инфляцийн түвшний төсөөлөл



Хэрэглээний үнийн улсын индекс 2015 оны дөрөв дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 0.9 хувь, оны эхнээс 2.9 хувь, өмнөх оны мөн үеэс 9.2 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сарынхаас 0.8 хувь, оны эхнээс 2.4 хувь, өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар тус тус өслөө. Суурь инфляци жилийн 11.0 хувь байв.

1.3 Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн эрх зүйн үндэслэл, хуулийн агуулга, ач холбогдол чиг хандлага.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж, “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 1.3-т “малын индексжүүлсэн даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг бүрэн бүртгэж даатгана” гэж заасан нь Малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог хуульчлан тогтоох эрх зүйн үндэслэл болсон юм.

Иймд Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөл, холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хурал хэлэлцэн 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдөр баталлаа. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 6 бүлэг 29 зүйлтэй бөгөөд энэ хуульд дараах зарчмын шинжтэй асуудлууд тусгагдсан байна. Үүнд:

- Даатгалын үйл ажиллагаанд баримтлах зарчим, малын хорогдлын босго үзүүлэлт, даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийн түвшин тогтоох, эрсдэл хуваарилах, нөхөн төлбөр олгох асуудал;
- Малын индексжүүлсэн даатгал болон давхар даатгалын үйл ажиллагаа;
- Малын индексжүүлсэн даатгалын сан, түүний төрөл, хэлбэр.

Малын индексжүүлсэн даатгал нь байгалийн давагдашгүй хүчин зүйлээс мал хорогдох эрсдэлээс хамгаалж, малчдын амьдралын баталгааг хангах зорилготой бөгөөд даатгалын

тохиолдол тус бүрд биш, сумын хэмжээнд гарсан малын хорогдлын хувиар босго үзүүлэлт буюу индекс тогтоож, түүнээс давж мал хорогдсон тохиолдолд бүх даатгуулагчид нөхөн төлбөр олгодог даатгалын хэлбэр юм.

Энэхүү даатгалын мөн чанар нь сумын хэмжээнд гарсан том малын хорогдол индексжүүлэн тогтоосон босго үзүүлэлтээс давсан бүх тохиолдолд тухайн даатгуулагчийн мал хорогдсон эсэхээс үл хамааран нөхөн төлбөр олгоход оршино.

Энэ хуульд заасны дагуу сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах, малыг төрлөөр нь, тухайн мал тоологдсон суманд даатгуулах, даатгалын нөхөн төлбөрийг индекст суурилан тооцох, малын хорогдлын хувь хэмжээг сумын түвшинд тодорхойлох зэрэг зарчмыг малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд баримтална.

Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрийг сумын малын хорогдлын индекст суурилан олгодгоороо ердийн даатгалаас ялгаатай юм. Малын индексжүүлсэн даатгалын гол онцлог нь даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчид учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд сумын хэмжээнд гарсан том малын хорогдлын хувь Засгийн газраас тогтоосон босго үзүүлэлтээс давсан тохиолдолд босго үзүүлэлтээс давсан хувь болон даатгалын үнэлгээнээс тооцож, даатгуулагчид нөхөн төлбөр олгоход оршино. Том малын хорогдлыг тухайн жилийн оны эхнээс хагас жилийн мал тооллого хүртэл хугацаанд зүй бусаар хорогдсон төлөөс бусад насны малын тоогоор тооцож гаргана. Сумын малын хорогдол” гэдэгт жилийн эцсийн болон хагас жилийн мал тооллогын албан ёсны дүн мэдээнд үндэслэн тооцоолсон том малын хорогдлын тоог ойлгоно. Даатгалын тохиолдол, эрсдэлийн түвшинг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах, даатгалын хураамжийг тогтоох зорилгоор сумын малын хорогдлын босго үзүүлэлтийг хуулиар тогтоожээ.

Хуульд сумын малын хорогдлын 1 дүгээр босго үзүүлэлт 6 хувь, 2 дугаар босго үзүүлэлт 30 хувь байхаар тусгасан байна. Сумын малын хорогдол, даатгуулагчийн тоо, хураамжийн орлого, нөхөн төлбөр зэргийг харгалзан хуулиар тогтоосон 1 дүгээр босго үзүүлэлтийг 1 хувиар, 2 дугаар босго үзүүлэлтийг 5 хүртэл хувиар нэмэгдүүлж, эсхүл бууруулан малын төрлөөр нь, сум тус бүрээр 3 жил тутам шинэчлэн тогтоох эрхийг Засгийн газарт олгов.

Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн оны хагас жилийн мал тооллогын дүнд үндэслэн сумын малын хорогдлын тоог гаргах бөгөөд уг тоог өнгөрсөн жилийн эцэст тоологдсон малын тоонд харьцуулан сумын малын хорогдлын хувийг малын төрлөөр нь, сум тус бүрээр гаргаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхээр хуульчиллаа. Дээр дурдсанаар нийтэд мэдээлсэн сумын малын хорогдол нь Засгийн газраас тогтоосон нэгдүгээр босго үзүүлэлтээс давсан бол даатгалын тохиолдол бий болсон гэж үзэж, даатгалын нөхөн төлбөрийг даатгагч банкаар дамжуулан олгох юм. Засгийн газраас тогтоосон хоёрдугаар босго үзүүлэлттэй уялдуулан даатгалын хураамжийг малчин, мал бүхий иргэн болон төр хариуцан төлөхөөр хуульд тусгасан байна.

Малын индексжүүлсэн даатгалын сан нь хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын сан гэсэн төрөлтэй байх бөгөөд сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журмыг Санхүүгийн зохицуулах

хороо болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байхаар болов. Хуулиар тогтоосон малын хорогдлын босго үзүүлэлттэй уялдуулан эрсдлийн түвшинг бага, дунд, дээд гэж ангилсан бөгөөд бага түвшинд гарсан эрсдэлийг малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр, дунд түвшинд гарсан эрсдэлийг даатгагчид хамтын эрсдэлийн санд оруулсан хөрөнгөөр, бусад эрсдэлийг давхар даатгалын компани эрсдэлээс хамгаалах болон алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгөөр хариуцахаар хуульчиллаа. Учир нь мал хувийн өмч учраас малчин, даатгуулагч өөрсдөө малаа хорогдуулахгүйн төлөө тэмцэх, хариуцлага хүлээх, түүнчлэн малыг даатгаж хураамж авсан даатгалын компани даатгалын тохиолдол бий болоход зохих журмын дагуу эрсдэлийг нөхөн төлөх, мөн мал сүрэг төрийн хамгаалалтад байгаа учраас байгалийн гамшиг тохиолдож, мал хорогдох үед төр оролцож, даатгагчийн хүчин чадлаас давсан хэмжээний хохирлыг барагдуулах үүрэгтэй. Энэ нь малын индексжүүлсэн даатгалыг илүү найдвартай, баталгаатай болгох юм.

Давхар даатгалын компанийг Засгийн газар үүсгэн байгуулах бөгөөд тэрхүү компани төрийн болон хувийн өмчийн оролцоотой хувьцаат компани байхаар хуульчлав. Давхар даатгалын компани дүрэмд заасан зарласан хувьцааг гаргах замаар хувийн өмчийн оролцоог нэмэгдүүлнэ. Давхар даатгалын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, эрсдэлээс хамгаалах болон алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх хөрөнгийг улсын төсвөөс нэг удаа олгохоор хуульчилсан бөгөөд цаашид давхар даатгалын компани хувьцаа худалдан борлуулсны орлого, хуримтлагдсан ашиг, хуульд заасан бусад эх үүсвэрээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, зах зээлийн зарчмаар ажиллах юм. Улсын Их Хурлаас баталсан Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль дараах ач холбогдолтой. Үүнд:

- Малын индексжүүлсэн даатгалын тогтолцоо бий болсноор зуд, байгалийн гамшгаас учирсан хохиролд улсын төсвөөс их хэмжээний зардал гаргадаг байсныг өөрчилж, төр, даатгалын компани, малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд хамтран хариуцаж, төсвийн ачаалал багасна.
- Даатгалын компани эрсдэлийнхээ тодорхой хэсгийг давхар даатгалын компанид даатгуулах замаар өрсөлдөөний зарчмаар, тогтвортой ажиллах боломж бүрдэнэ.
- Малчин индексжүүлсэн даатгалд хамрагдсанаар зээл олгосон банк, санхүүгийн байгууллагын эрсдэл буурч, санхүүгийн үйл ажиллагаа хэвийн болно.
- Малын индексжүүлсэн даатгалын тогтолцоо бий болсноор төр, хувийн хэвшлийн түншлэл нэмэгдэж, цаашид олон улсын давхар даатгалд нэгдсэн журмаар хамрагдах боломж бүрдэнэ.

ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО

2.1 Гүйцэтгэл хураангуй

2.1.1 Зорилго, зорилт

Алсын хараа

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компани нь “Монгол улсын даатгалын тогтолцоог олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангана” гэсэн алсын хараатай.

Эрхэм зорилго

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компани нь “Давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх замаар Монголын даатгал, санхүүгийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулна” гэсэн эрхэм зорилготой.

Зорилт

- ✓ Малчдын амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.
- ✓ Үндэсний давхар даатгалын тогтолцоог үүсгэх суурь болно.
- ✓ Монгол улсын давхар даатгалын чиг хандлагыг тодорхойлогч компани байна.
- ✓ Дотоодын давхар даатгалын санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ.
- ✓ Даатгалын зах зээлд тогтвортой оршин тогтнож, байгууллагын санхүүгийн тогтвортой өсөлтийг хангаж ажиллана.
- ✓ Олон улсын давхар даатгагчдыг Монголын даатгалын зах зээлтэй холбох гүүр болж, олон улс дахь бизнесийн харилцаагаа өргөжүүлнэ.
- ✓ Үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөдөө аж ахуйн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.
- ✓ Даатгалын чадварлаг боловсон хүчинг бэлтгэнэ.


2.2 БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

2.2.1 Бизнес ба түүний түүх

1999-2002 онд ган зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдлээс нийт 11.2 сая мал хорогдож манай орны эдийн засагт 333 тэрбум төгрөгийн шууд хохирол учирснаас үүдэн Монгол Улсын Засгийн Газар, Дэлхийн Банк, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага зэрэг олон улсын хандивлагч нартай хамтран Монгол орны зах зээлийн судалгааг 2001 оноос эхлэн хийж, энэхүү хүндрэл бэрхшээлийн эсрэг дэлхийн жишигт нийцсэн даатгалын тогтолцоог нэвтрүүлбэл үр дүнтэй байж болохыг тогтоосон. Улмаар өнөөгийн нөхцөлд индекс суурилсан малын даатгалын хэлбэр Монгол Улсын хувьд тохиромжтой эсэхийг тогтоох зорилгоор “Малын индексжүүлсэн даатгал” /Цаашид МИД гэх/ төслийг газар зүйн бүс бүсийн онцлогийг илэрхийлэхүйц аймгуудыг сонгон туршилтын журмаар 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Зуд турхан, байгалийн гамшигт үзэгдлийн дараа малчдын амьжиргаа доройтдог эмзэг байдлыг бууруулж тогтвортой болгох, ингэхдээ зөвхөн даатгалд хамрагдсан малчдад зохих хэмжээний даатгалын нөхөн олговрыг олгож хохирлыг нөхөх, бэлэн мөнгө, мал олгож малчдыг бэлэнчлэх сэтгэлгээнд сургахаас зайлсхийх, даатгалын салбарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, улмаар даатгалын компаниуд энэхүү өвөрмөц аргачлалаар малыг даатгаж олон улсын жишгийг даган зах зээлийн зарчмаар цаашид хөгжих боломжийг нэмэгдүүлэх, зуд болон байгалийн гамшигийн үед Засгийн газрын үүрэх ачааг хөнгөвчлөх, гамшигийн хохирлыг дан ганц төрөөс хариуцах биш тодорхой хэсгийг хувийн хэвшил, олон улсын давхар даатгалын хөрөнгийн эх үүсвэрээр арилгах тогтолцоог бий болгох, энэхүү тогтолцоог тогтвортой оршин тогтнох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь МИД төслийн зорилго байлаа.

Зураг 20. МИД-д даатгуулсан малчин өрхийн тоо.



Эх сурвалж: МИД төсөл

МИД төслийн хүрээнд 2006-2014 онд 9 удаагийн борлуулалтаа хийж, 8 удаагийн нөхөн төлбөр олгоод байна. Нийт давхардсан тоогоор 83,000 гаруй малчин өрх даатгалд хамрагдаж, 15,619 малчин өрх нөхөн төлбөр аваад байна. МИД-ын талаарх малчид, иргэдийн ойлголт сайжирч ач холбогдлыг нь танин мэдэж МИД-ыг борлуулах зах зээл, худалдан авах эрэлт байгааг харуулж байна.


Зураг 21. Хохирол нөхөлтийн харьцаа.



Эх сурвалж: МИД төсөл

Төсөл хэрэгжсэн 2006-2013 онуудад даатгуулсан малчин өрхөөс нийт 5,5 тэрбум төгрөг төвлөрүүлж 15,619 малчинд нийт 3,2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Малчид МИД-д төлсөн хураамжийн хэмжээ, тухайн орон нутагт гарсан эрсдэлийн хэмжээтэй уялдан харилцан адилгүй нөхөн төлбөрийг авч байна. /Зураг 21/

Зураг 22. МИД-ын нөөц сан



Эх сурвалж: МИД төсөл


2006 оноос хойш Засгийн газрын нөөцийн дансыг жил бүр байгуулан малчдын мал сүрэгт учрах тодорхой хэмжээний эрсдэлийг хамгаалж ирсэн. 2007, 2008, 2009 оны нөхөн төлбөр Малын даатгалын дундын данс болон Засгийн газрын нөөцийн дансыг давж Дэлхийн банкны нөхцөлт зээлийн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна. Харин 2010-2013 онуудад Засгийн газрын нөөц хуримтлагдаж 1,5 тэрбум төгрөгт хүрээд байна. /Зураг 22/

2010 оны борлуулалтын улирлаас эхлэн дунд түвшний эрсдэлийн тодорхой хэмжээний

эрсдэлийг олон улсын давхар даатгагчид даатгуулах зорилгоор судалгаа, уулзалтуудыг хийсний үр дүнд анхны гэрээг SKOP (SCOR) компанитай байгуулсан юм. Харин 2012 оны борлуулалтын улирлаас Засгийн газрын хариуцах эрсдэлийг бууруулах зорилгоор давхар даатгуулах ажлыг эхлүүлж, олон улсад нэр нөлөө бүхий тэргүүлэгч давхар даатгагч нарт МИД-ыг танилцуулж, судалгаа хийсний үндсэн дээр СвиссРе (Swiss Re) компанитай давхар даатгалын гэрээ байгуулсан.

Одоо жил бүр давхар даатгалын гэрээгээ шинэчлэн олон улсын давхар даатгагч нартай байгуулж хэвшээд байна. МИД-ын хүрээнд гарч болзошгүй нөхөн төлбөрийг Дэлхийн банкны нөхцөлт зээлийн бус хөрөнгөөр санхүүжүүлэх чадавхийг дээрх байдлаар жил бүр нэмэгдүүлэхийг зорьж ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлж эхэлсэн 2006 онд Дэлхийн банкны нөхцөлт зээлийн бус хөрөнгөөр санхүүжүүлэх хэмжээ 122 сая төгрөг байсан бол хэрэгжилтийн үр дүнгээр 2014 оны байдлаар 6,1 тэрбум төгрөгт хүрээд байна. /Зураг 23/

Зураг 23. Зээлийн бус хөрөнгөөр МИД-ын нөхөн төлбөрийг санхүүжүүлэх чадавхи.



Эх сурвалж: МИД төсөл


МИД төслийн хүрээнд малчдыг мэдээллээр, даатгалын компаниудыг бүтээгдэхүүнээр хангаад зогсолгүй энэ шинэлэг харилцаан дахь төр болон бусад оролцогчдын эрх үүргийг тодорхой болгосон хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. 2014 оны 06-р сарын 13-ны өдөр батлагдсан “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль” 6 бүлэг 29 зүйлтэй бөгөөд энэ хуульд даатгалын үйл ажиллагаанд баримтлах зарчим, малын хорогдлын босго үзүүлэлт, даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийн түвшин тогтоох, эрсдэл хуваарилах, нөхөн төлбөр олгох асуудал, МИД болон давхар даатгалын үйл ажиллагаа, МИД-ын даатгалын сан, түүний төрөл, хэлбэрийн талаар тусгасан байна.

2.2.2 Зах зээлийн нөхцөл, төлөв байдал

Малын даатгалын зах зээл

2014 оны жилийн эцсийн байдлаар малын даатгалын зах зээл дээр нийт 47.6 сая мал тоологдсон бөгөөд малын нийт үнэлгээ 10.8 их наяд төгрөгт хүрээд байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой, нэгж малын үнэлгээ өсч байна. 2017 он хүртэл малын тоо, малын үнэлгээний өсөлтийг тооцож үзэхэд өсөх хандлагатай нь ажиглагдаж байна.


Зураг 24. Малын даатгалын зах зээл (нийт малын тоо, үнэлгээ)



Эх сурвалж: МИД төсөл

Даатгуулсан малын тооны өсөлтийг харахад төсөлд анх хамрагдсан 3 аймаг (Баянхонгор, Увс, Хэнтий аймгууд)-ийн өсөлтийн хувь 4,3 хувьтай байсан бол 2008 оноос аажмаар өсч 2014 оны байдлаар 29 хувиар өссөн байна. Даатгуулсан малын өсөлтийн хувь нь даатгуулсан малчдын өсөлтийн хувьтай ойролцоо өсөлттэй байна.

Зураг 25. Даатгуулсан малын тоо, малын үнэлгээ.



Эх сурвалж: МИД төсөл

Даатгалын үнэлгээний хувьд харахад төсөлд анх хамрагдсан 3 аймаг (Баянхонгор, Увс, Хэнтий аймгууд)-ийн хувьд даатгалын үнэлгээний дээд үзүүлэлт 39%-д хүрч байгаад 2009-2010 онд буурч, цаашид тогтворжсон байна. Бусад аймгуудын хувьд ч мөн даатгалын үнэлгээний хувь буурсан үзүүлэлт ажиглагдлаа. Энэ нь даатгуулах үнэлгээнээс ихэд хамааралтай бөгөөд малчид малаа бага үнээр үнэлэн даатгуулж байна. Цаашдын даатгуулах малын тоо, малын үнэлгээг урьдчилсан байдлаар тооцож үзэхэд өсөх хандлагатай байна. Нийт малын 7-9 хувийг, даатгалын үнэлгээний 0,3-0,5 хувийг даатгаж байна. Иймд малыг даатгах зах зээл хангалттай байгааг харуулж байна.

2.2.3 Эрхлэх гэж буй даатгалын үйл ажиллагаа, даатгалын хэлбэр

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 356 тоот тогтоолоор батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-т заасан “мал амьтдын даатгал” (МИД), “газар тариалангийн даатгал”, болон бусад хэлбэрийн даатгалд давхар даатгалын үйлчилгээ үзүүлнэ. Эхний жилүүдэд МИД-ын давхар даатгалын үйлчилгээг үзүүлэх бөгөөд цаашид газар тариалангийн даатгал болон бусад даатгалд хэрэгцээтэй давхар даатгалыг судалж туршин нэвтрүүлэх болно. МИД-ын талаар дэлгэрэнгүй авч үзье.

Малын индексжүүлсэн даатгал

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд зааснаар МИД-ын үйл ажиллагаа нь даатгуулагчид учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд сумын хэмжээнд гарсан том малын хорогдлын хувь босго үзүүлэлтээс давсан тохиолдолд босго үзүүлэлтээс давсан хувь болон даатгалын үнэлгээнээс тооцож, даатгуулагчид нөхөн төлбөр олгох онцлогтой. Засгийн газраас аймаг, сум бүрт малын төрлөөр ялгавартай тогтоосон том малын хорогдлыг хувийг хэлэх

бөгөөд даатгуулагчийн эрсдэл хүлээх нэгдүгээр босго үзүүлэлт, даатгагчийн эрсдэл хүлээх хоёрдугаар босго үзүүлэлттэй байна. Нэгдүгээр босго үзүүлэлт 6 хувь, хоёрдугаар босго үзүүлэлт 30 хувь байна.

МИД-ын үйл ажиллагааг СЗХ-ноос МИД-ын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-тай давхар даатгалын гэрээ байгуулсан даатгагч эрхэлнэ.

Малын индексжүүлсэн даатгалын гэрээ

МИД-ын үйл ажиллагаа эрхлэх даатгагч нь малчин мал бүхий иргэн, хуулийн этгээдтэй батлагдсан даатгалын гэрээг байгуулна. МИД-ын гэрээнд даатгуулах малын төрөл, хураамжийн хэмжээ, даатгуулсан малын үнэлгээ, нөхөн төлбөр олгох талаар тусгасан байна. Даатгалын гэрээг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-н Төлөөлөн удирдах зөвлөл батална.

Малын давхар даатгалын гэрээ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь даатгагчтай малын давхар даатгалын гэрээг байгуулах бөгөөд даатгагчийн өмнө хүлээсэн үүргээ олон улсын давхар даатгалын компанид хэсэгчлэн шилжүүлж болно.

2.2.4 Даатгалын хураамж

Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн тооцоолол

МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн тооцооллыг Глобал Агриск корпораци¹ малын хорогдлын дүн мэдээнд суурилан боловсруулсан. Энэхүү аргачлалаар боловсруулсан хураамжийн хувийг 2006-2014 оны МИД-ын борлуулалтын улиралд ашиглаж байна.

Энэхүү хураамж тооцоолох аргачлалыг 2011 онд актуарч Дэвид Коегэл хянаж үзээд Глобал Агриск корпорацийн боловсруулсан аргачлалыг тохиромжтой гэж үзсэн. Мөн онд “Цаг уурын хүчин зүйл малын хорогдолд нөлөөлөх нь” судалгааг Колумбийн их сургуулийн багаар хийлгэхэд цаг уурын өөрчлөлт нь тодорхой давтамжгүй, малын хорогдлын дүн мэдээнд нэмэлт өөрчлөлт оруулан хураамжийн хувийг тооцоолох шаардлагагүй гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Иймд МИД-ын хураамжийн хувийг Глобал Агриск корпорацийн боловсруулсан аргачлалаар тооцоолж, 2-3 жилд шинэчлэн боловсруулан ашиглаж байна. Хураамж тооцоолох аргачлалын хувьд өнгөрсөн 27 жилийн аймаг, сум, малын төрөл тус бүрийн малын хорогдлын хувьд үндэслэн дараах тооцооллуудыг хийж гаргасан.

1. Өгөгдлийг цэвэрлэх шүүх

1972 оноос хойшхи малын хорогдлын өгөгдлийн хувьд зөвхөн 1 жилийн өгөгдөлтэй, зарим нэг өгөгдөл алдаатай, дутуу тул энэхүү өгөгдлийг ашиглан хураамжийн хувь тооцоолох боломжгүй байсан. Иймд сумын хэмжээнд эрсдэлийн шинжилгээний тохируулга болон сум хоорондын орон зайн хамаарал ашигласан өгөгдлийн баазад шүүлт хийсэн. 2004 онд Энэтхэг улсын мэргэшсэн компаниар (RMSI) өгөгдлийн баазад шүүлт хийж өгөгдлийн баазыг цэвэрлэсэн. 2008 оноос эхлэн МИД-ын хүрээнд Үндэсний статистикийн хороо /цаашид ҮСХ гэх/ нь жилд 2 удаа

¹ Малын индексжүүлсэн даатгал төслийн даатгалын асуудлаарх олон улсын зөвлөх байгууллага бөгөөд төсөлтэй 2006 оноос хойш хамтран ажилласан.

мал тооллогын ажлыг зохион байгуулдаг болсон ба хагас жилийн мал тооллогыг түүвэр судалгааны аргаар явуулж байгаа юм. Иймд 2008 оноос хойшхи мэдээллийг ҮСХ-ноос авч ашигласан.

2. Хохирлын зардлыг тооцоолох

МИД-ын алдагдлын зардлыг тооцоолохдоо өнгөрсөн 27 жилийн малын хорогдлын түүхэн мэдээлэлд үндэслэн сум, малын төрөл тус бүрийн хоёрдугаар босго хүртэлх болон хоёрдугаар босгоос давсан эрсдэлийн нөхөн төлбөр олгох хувь болон алдагдлыг зардлыг тус бүрт нь тооцоолж гаргасан. Ингэхдээ тухайн сумын ямаа, адуу, үхэр, тэмээн сүргийн тоо 5000-д хүрэхгүй тохиолдолд хонины хорогдлоор төлөөлүүлэн тооцсон. Мөн тухайн сумын зэргэлдээ сум дахь алдагдлын зардлыг хоёрдугаар босго хүртэлх болон хоёрдугаар босгоос давсан хувьд тооцоолон гаргасан. Зэргэлдээ сумын хорогдол нь тухайн сумын хорогдолд ихээхэн нөлөөлдөг.

Зураг 26. 1989-2013 оны малын дундаж хорогдлын хувь.



Эх сурвалж: МИД төсөл

Тухайн сумын малын хорогдолд зэргэлдээ сумын малын хорогдлын нөлөөллийг авч үзсэн. Өөрөөр хэлбэл үндсэн сумын утгуудыг зэргэлдээ сумын утгуудтай дундажлах замаар хохирлын хувийг тэгшитгэсэн.

3. Гамшгийн эрсдэлийг тооцоолох, нэмэгдэл өгөх

Дээрх тооцоолсон цэвэр эрсдэл дээрээ 5 төрөл малын гамшигийн эрсдэлийг нэмж тооцоолж гаргасан.

Дээрх аргачлалын дагуу МИД-ын хураамжийн тооцооллыг 330 сум 5 төрлөөр хийсэн ба даатгуулагч малчнаас авах дундаж хураамж нь 4 орчим хувьтай байна.

МИД-ын давхар даатгалын хураамжийн тооцоолол

ХАА-н давхар даатгал ХК-ийн хувьд үйл ажиллагааны үндсэн орлогоо давхар даатгалын хураамжаас болон хөрөнгө оруулалтын орлогоос олох болно. Өнгөрсөн хугацаанд МИД-ын эрсдэлийн тодорхой хэсгийг олон улсын давхар даатгалд шилжүүлэх зорилгоор төслийн зүгээс эрсдэл тооцоолол болон давхар даатгалын хураамж тооцооллыг хийж ирсэн. Оролцогч даатгалын компаниудаас авах МИД-ын давхар даатгалын хураамжийг дараах аргачлалаар тооцож гаргана.

1. Өнгөрсөн хугацааны нөхөн төлбөрийн хэмжээг сум, малын төрөл тус бүрээр гаргах

Тухайн даатгалын компани тус бүрийн хийсэн МИД-ын борлуулалтын хариуцлага буюу эрсдэлийг сум, малын төрөл тус бүрээр өнгөрсөн 27 жилийн малын хорогдлын хувиар үржүүлэн жил бүр гарах нөхөн төлбөрийн хэмжээг гаргана.

2. Өнгөрсөн 27 жилийн алдагдлын харьцааг тооцоолж гаргах

Сум болон малын төрөл тус бүрээр тооцоолж гаргасан нөхөн төлбөрийн хэмжээг нийт улсын хэмжээнд нэгтгэн тухайн жил бүр гарах нөхөн төлбөрийн нийт хэмжээг гаргана. Улмаар тухайн жилийн нийт нөхөн төлбөрийн хэмжээг нийт хураамжийн орлогод харьцуулан жил бүрийн алдагдлын харьцааг тооцоолно.

3. Алдагдлын харьцааны дунджийг олж, үйл ажиллагааны нэмэгдэл өгөх

27 жилийн алдагдлын харьцааны дунджийг олж, ХАА-н Давхар Даатгал ХК-ний өөрийн үйл ажиллагааны нэмэгдлийг өгч үржүүлснээр тухайн даатгалын компаниас авах МИД-ын давхар даатгалын хураамж гарч ирнэ.

2.2.5 Нөхөн төлбөр олголт

МИД-ын тохиолдлыг тодорхойлох

Даатгалын тохиолдол бий болсон, нөхөн төлбөр олгох нөхцөл бүрдсэн эсэхийг тодорхойлохдоо Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6.3-т заасны дагуу ҮСХ-ноос нийтэд хүргэсэн сум бүрийн малын хорогдлын хувийн талаарх мэдээлэлд үндэслэнэ.

Даатгуулагчийн тодорхой төрлийн малаа даатгасан сумдын тухайн төрлийн малын хорогдлын хувь нь тухайн сумдын хувьд Засгийн газраас тогтоосон нэгдүгээр босго үзүүлэлтээс давсан буюу МИД-ын гэрээнд заасан даатгалын тохиолдол бий болсон гэж үзэж нөхөн төлбөр олгоно.

Нөхөн төлбөрийг тооцоолох

ҮСХ-ноос гаргасан хагас жилийн мал тооллогын мэдээнд үндэслэн нөхөн төлбөрийг тооцоолох бөгөөд энэхүү тооцоог давхар даатгалын компани өөрийн програм хангамжийг ашиглан тооцоолно. Тооцооллыг даатгуулагч, даатгагч тус бүрээр гаргана.

Даатгагчид “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-аас хүлээн авсан нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг өөрийн цахим мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулган шалгах, сумдын даатгалын төлөөлөгч нарт илгээж тулган шалгалт хийх зэргээр хянаж болно.

ХАА-н Давхар Даатгал ХК нь нөхөн төлбөрийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг тооцоолж гаргана. Үүнд, хамтын эрсдэлийн сан, нөөц сан, алдагдлаас хамгаалах сан болон олон улсын давхар даатгагчаас авах нөхөн төлбөрүүд орно.

Нөхөн төлбөр олгох

Хамтын сангийн гишүүдийн хурал болон давхар даатгалын компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гарсан үед давхар даатгалын компанийн гүйцэтгэх захирал нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг зохион байгуулна.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК даатгагчийн арилжааны банкин дах дансаар нөхөн төлбөрт шаардагдах мөнгийг шилжүүлнэ. Даатгагч нөхөн төлбөрийг хүлээн авч даатгуулагчдад олгох нөхөн төлбөрийг даатгалын тохиолдол гарсан сум бүрт байгаа гэрээт арилжааны банкны салбарт шилжүүлнэ.


2.3 МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.3.1 Зах зээлийн шинжилгээ

Макро эдийн засгийн хүчин зүйл

Даатгал /давхар даатгал/-ын зах зээл нь макро эдийн засгийн нэг гол тулгуур үзүүлэлт болж өгдөг. Даатгалын салбарын хөгжлийг харуулдаг гол үзүүлэлт бол дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх даатгалын хураамжийн орлого юм. Олон улсын туршлагаас харахад тухайн орны эдийн засгийн хөгжил өндөр байхын хэрээр даатгалын салбарын ДНБ-д эзлэх хувь өндөр байдаг.

Зураг 27. ДНБ-д даатгалын нийт хураамжийн эзлэх хувь.




Эх сурвалж: OECD, National Central Bank

Санхүүгийн зохицуулах хороо болон бусад байгууллагуудын тайлангаас харахад даатгалын зах зээл нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсч 2014 оны байдлаар даатгалын нийт хураамжийн орлого ДНБ-ний 0.5%-тай тэнцүү буюу 108,7 тэрбум төгрөг байгаа юм. Энэ нь өмнөх оны даатгалын нийт хураамжтай харьцуулахад даруй 16%-иар өссөн үзүүлэлт юм. Дараагийн жилүүдэд энэхүү өсөлт нь удааших боловч ерөнхийдөө өсөх хандлагатай байгаа юм. Мөн өндөр хөгжсөн орнуудад даатгалын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь 10-15 хувьтай байна.

Монголын санхүүгийн салбарт даатгалын салбарын эзлэх хувийг харахад 0,7 хувьтай тэнцүү байна. Өндөр хөгжсөн орнуудын хувь энэ үзүүлэлт 20 хувьтай (банк 70%, даатгал 20%, бусад салбар 10%) байдаг байна. /Зураг 28/

Зураг 28. Санхүүгийн салбарт эзлэх хувь.



Эх сурвалж: YCX

Дээрх ерөнхий үзүүлэлтээс харахад даатгалын зах зээлийн боломж байгаа ба зах зээлийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Микро эдийн засгийн хүчин зүйл

СЗХ-ноос гаргасан даатгалын зах зээлийн тайлан, мэдээнд үндэслэн даатгалын салбарын хөгжлийн сүүлийн жилүүдийн динамик үзүүлэлтүүдийг харьцуулж үзэхэд даатгалын зах зээл эрчимтэй хөгжиж, даатгалын байгууллагуудын тоо, даатгагчдын нийт хөрөнгө, хураамжийн орлого, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ өсч байна.

“Олон салбарт техникийн туслалцаа үзүүлэх төсөл”-өөс гаргасан Монголын даатгалын зах зээлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах болон давхар даатгалын чадавхийг хөгжүүлэх судалгаанд 2019 онд даатгалын хураамжийн нийт орлого нь 220 гаран тэрбум төгрөгт хүрэхээр урьдчилсан тооцоолол хийсэн байна. 2013 оны хувьд манай даатгалын компаниуд 25,9 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж гадаадын давхар даатгалд төлсөн байгаа нь нийт хураамжын 27,6 хувьтай тэнцүү байгаа юм. Эндээс 460 орчим сая төгрөг нь ХААДД-ын хураамжинд төлсөн болно. 2014 оны хувьд манай даатгалын компаниуд 34,6 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж гадаадын давхар даатгалд төлсөн байгаа нь нийт хураамжийн 31,8%-тай тэнцүү байна.

Мөн 2014 оны жилийн эцсийн байдлаар малын даатгалын зах зээл дээр нийт 47,6 сая мал тоологдсон бөгөөд малын нийт үнэлгээ 10,8 их наяд төгрөгт хүрээд байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой, нэгж малын үнэлгээ өсч байна. 2017 он хүртэл малын тоо, малын үнэлгээний өсөлтийг хийж үзэхэд өсөх хандлагатай нь ажиглагдаж байна.

2.3.2 Маркетингийн стратеги

Бизнес төлөвлөгөөнд тодорхойлогдсон алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудын хүрээнд дотоод боломж, санхүүгийн төлөвлөгөөт тооцооны ашигтай хувилбарыг үндэслэн Монголдоо анхны ХАА-н давхар даатгалын компанийн хувьд зах зээлийг хошуучлагч нь байж, **зах зээлийн лидерийн стратегийг** баримтлан, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах ба шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, чанараа сайжруулах стратегитай хослуулна. Нийтийн, арилжааны болон холимог даатгалын эрэлт хэрэгцээний дагуу бүтээгдэхүүнээ бэлтгэж, бүхэлдээ эрэлт нийлүүлэлтийн зохистой тэнцлийг хангахад чиглэгдсэн бодлого боловсруулж баримтална.

Үйлчлүүлэгчийн төлөв байдлын тухайд өнгөрсөн хугацаанд МИДТ-ийн хүрээнд 2006 оноос хойш одоог хүртэл МИД болон даатгалын ач холбогдлын талаар хөдөө орон нутгийн удирдлагууд, ард иргэд, малчдад сургалт сурталчилгааг хийж ирсэн. Төслийн хүрээнд нүүр тулсан сургалтыг жил бүр зохион байгуулж, малын даатгал болон бусад даатгалын ач тус, өгөөжийн талаар ухуулга сургалт хийсэн. Тиймээс МИД-ын бүтээгдэхүүний талаар тодорхой мэдлэгтэй болсон бөгөөд цаашид ХАА-н даатгалын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлж үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангаж ажиллана.

Өрсөлдөөний тухайд ХАА-н Давхар Даатгал ХК нь дотоодын давхар даатгалын зах зээл дээр олон улсын давхар даатгал компаниудтай өрсөлдөж цаашид бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, зах зээлээ өргөжүүлэх, олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлж, өмнөө тавьсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж ажиллана.

2.3.3 Маркетингийн иж бүрдэл

Үнийн бодлого

Үнийн бодлогыг тодорхойлохдоо даатгуулагч, даатгагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд суурилсан, төлөвлөсөн орлогыг бүрдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх, ХАА-н давхар даатгалын зах зээлд эрэлт хэрэгцээтэй шинэ бүтээгдэхүүн гаргах, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зэрэгт чиглүүлэх бөгөөд энэ нь зорилтот зах зээл, бүтээгдэхүүний чанарын түвшинг дээшлүүлэх, зах зээлд байр сууриа олж, бэхжүүлэх, боломжит үр дүн олох, ХАА-н давхар даатгалын хэрэгцээг хангахуйц үйлчилгээг явуулахад чиглэсэн байна. Тухайлбал, даатгуулагч, даатгагч, давхар даатгагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн даатгалын хураамжийг авч, давхар даатгалын эрсдэлийг хангахуйц нөөц сантай болох шаардлагатай.

Борлуулалтын төлөвлөгөө

Бизнес төлөвлөгөөний зах зээлтэй харилцах хамгийн чухал үзүүлэлт бол бүтээгдэхүүний борлуулалт буюу хэзээ, хаана, хэний хэрэгцээнд хэдий хэмжээгээр ямар чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах тухай асуудал байдаг бөгөөд үүнийг борлуулалтын төлөвлөгөөгөөр

зохицуулна. Тухайлбал, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зардлыг хэмнэх, төлөвлөсөн хугацаанд эрэлтэнд нийцүүлэн зорилгот зах зээл, түүний хэсгүүдэд чанар сайтай хэрэгцээт бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчийн таашаалд нийцүүлэн нийлүүлж, борлуулалтын төлөвлөсөн орлогыг баталгаатай олох нөхцөл бололцоог хангаж, нөөц сангаа нэмэгдүүлэхэд оршино.

Борлуулалтыг идэвхижүүлэх арга хэмжээ

Хамгийн гол асуудал нь борлуулалтыг хүчтэй идэвхижүүлэх үр ашигтай арга хэмжээг сонгон авах явдал юм. Борлуулалтыг идэвхижүүлэх арга хэмжээг гол төлөв эдийн засгийн шинжтэй, хямд төсөр сувгаар хэрэгжүүлэх шаардлагатай юм.

МИД-ын тухайд, борлуулалтын улирлын дундуур орон нутагт даатгалын өдрийг зохион байгуулж сурталчилгааг хийх нь үр дүнтэй байдаг нь МИДТ-ийн туршлагаас харагдсан. Иймд дараа дараагийн жилүүдэд дараах идэвхижүүлэлтийн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд ХАА-н Давхар Даатгал ХК-ийн зүгээс борлуулалтыг идэвхижүүлэх зорилгоор дараахи ажлуудыг жил бүр зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. Үүнд:

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Сангийн яам, Монголбанк, СЗХ-ны хүрээнд:

1. МИД-ыг албан журмын даатгал болгох талаар судалгаа хийж, асуудлыг шийдвэрлүүлэх /малчин өрх 200 хүртэл толгой малыг заавал даатгуулах эсвэл нийт малынхаа нэг төрлийг заавал даатгуулж үлдсэн хэсгийг сайн дураар даатгуулдаг зохицуулалт хийх/.
2. Харилцагч арилжааны банкуудтай ярилцаж малчны зээлийн журамд шаардлагатай гэж үзвэл холбогдох хуульд нэмэл өөрчлөлтийг оруулах, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Сангийн яамаар дэмжүүлэх; /зээлдэгчийн амь насны даатгал хийхээс гадна барьцаа болгож буй малыг давхар даатгадаг байх/
3. МИД нь тээврийн хэрэгслийн оношилгоо болон жолоочийн албан журмын даатгалтай хугацааны хувьд давхацдаг учир хугацааг зөрүүлэх талаар холбогдох судалгааг хийж зөвлөлийн гишүүдэд тодорхой санал хүргүүлэх, шийдвэрлүүлэх.

Сангийн яам, ТУЗ-ийн хүрээнд:

1. МИД-ын сургагч багш болон ХААДД ХК-ийн төлөөллийг цаашид аймаг сумдад авч ажиллуулах /улирлын чанартай эсвэл бүсчилсэн байдлаар зохион байгуулах/ боломж байгаа эсэхийг Сангийн яам болон ОУ-н байгууллагуудаас дэмжлэг авах боломжийг судлах, хэрэгжүүлэх;
2. МИД-ын сургагч багш нарт харилцаа холбоо болон бичиг хэргийн зардлыг шийдвэрлэх боломж байгаа талаар судлах;
3. Аймаг сумдын болон багийн засаг дарга нарын ажлын байрны тодорхойлолтонд МИД-ын талаар тусгаж өгөх, ингэхдээ ажлын биелэлтэнд нөлөөлхүйц байдлаар тусгах талаар удирдлагуудтай хэлэлцэж ажил хэрэг болгох;

ХААДД ХК-ийн хүрээнд:

1. МИД-ын манлай даатгалын төлөөлөгчийн сонгон шалгаруулах уралдаан зарлаж урамшуулах.

2. Орон нутгийн удирдлагууд, малчид, иргэдэд компанийхаа үйл ажиллагааг сурталчилах, МИД-ын борлуулалтын үйл ажиллагаатай танилцах, борлуулалтын үйл ажиллагааг идэвхижүүлэх, оролцогч даатгалын компаниудын салбар нэгж, даатгалын төлөөлөгчдийн ажлын явцтай танилцах, зөвлөгөө өгөхөд томилолтын ажиллах.
3. Төрөөс хэрэгжүүлж буй урамшуулал, бусад хөтөлбөртэй МИД-ын бүтээгдэхүүнийг холбох
4. МИД-ын даатгалын хураамжийг бэлэн мөнгөөр бус малаар орлуулж төлөх боломж байгаа талаар судлах;
5. Малын хорогдол болон нөхөн төлбөрийн талаарх статистик мэдээг бүх мэдээллийн суваг болон ухуулах хуудсаар тараах; /Малчид зөвхөн ган зуд болсоноос бус өдөр тутмын малын хорогдлоо багийн даргадаа идэвхтэй мэдээлж байх нь нөхөн төлбөр авах боломжтой гэдгийг сайн мэддэггүй тул нэгдсэн мэдээллийг өгч хорогдлын мэдээ өгөх идэвхийг дээшлүүлэх./
6. Улс, аймаг сумдын аварга малчинд тавих шалгуурт тавигддаг “малаа даатгалд хамруулсан байх” гэсэн асуудлыг илүү нарийвчлан оруулж өгөх, малын нийт үнэлгээний тодорхой хувиас доош даатгуулахгүй байх заалтыг тусгах;

Банкуудын хүрээнд:

1. Арилжааны банкуудтай хамтран малчдад банк санхүүгийн болон зээлийн үйлчилгээ авахыг хялбаршуулан хөнгөвчлөх
2. Харилцагч арилжааны банкууд малчдад хураамжийн зээл олгож байгаа болон малчны зээлийн хөнгөлөлтийн талаар орон нутгийн салбарууддаа мэдээлж ажиллах талаар анхаарч ажиллах, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь албан байгуулагтай нэмэлт гэрээ байгуулах тал дээр анхааран ажиллах.

Хөтөлбөрт оролцогч даатгалын компаниудын зүгээс дараахи ажлуудыг хэрэгжүүлж хэвших шаардлагатай. Үүнд:

1. Даатгалын компаниудын зүгээс аймаг болгонд МИД-ын борлуулалтын үеэр даатгалын өдөрлөгийг зохион байгуулж хэвших.
2. Олон жил даатгалд хамрагдсан малчдад даатгалын компанийн зүгээс тодорхой хэмжээний урамшууллыг олгох

Борлуулалтын суваг

2015 оны борлуулалтын улирлаас эхлэн Төрийн Банктай 253/07/01 тоот хамтран ажиллах гэрээг 2015 оны 3 сарын 30-нд, Хаан Банктай 241/07/02 тоот хамтран ажиллах гэрээг 4 сарын 10-нд байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээний зорилго нь борлуулалтын сувгаа нэмэх, МИД-д малаа даатгуулсан малчны зээлийг сарын 0,2 пунктээр бууруулан олгох, түүнтэй холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилготой. Ингэснээр борлуулалтын зардал багасаж, МИД-ын борлуулалт өсөх боломжтой.

Зар сурталчилгаа

Зар сурталчилгааны зорилго нь “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК -ийн үйл ажиллагааг олон түмэнд өргөн сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлээ өргөжүүлэхэд оршино. Зар

сурталчилгааг түгээх суваг болох телевизийн суваг, хэвлэл, үзэсгэлэн, хурал, цуглаан, семинар, тайлан өдөрлөг, нээлттэй хаалганы өдөрлөг, факс, гар утас зэргийг ашиглаж явуулна. 2015-2016 оны МИД-ын борлуулалтын улиралын хувьд хөдөө орон нутагт малчид төслийн үйл ажиллагаа дуусч байгаа гэсэн буруу ойлголт их байна. Иймд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн зүгээс МИД хөтөлбөрийг төрийн өмчит “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК цаашид тогтвортой зохион байгуулахаар болсон УИХ болон Засгийн газрын шийдвэрийг малчдад хүргэх хэрэгтэй байна. МИД-ыг сурталчлан таниулах ажлын хүрээнд Монголын үндэсний олон нийтийн радио телевиз /МҮОНРТ/-тэй, Малчин телевизтэй дараахи ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүнд:

1. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК -ийн талаар Шторк, зар сурталчилгаа
2. МИД болон Хөдөө аж ахуйн Давхар Даатгалын талаар нэвтрүүлэг
3. Монголын үндэсний олон нийтийн радио телевиз Хурд мэдээллийн агентлагтай хамтран нэвтрүүлгүүд, мэдээллийн хөтөлбөр, зар сурталчилгаа явуулах
4. Малчин телевизтэй хамран нэвтрүүлэг, шууд ярилцлага, реклам зар сурталчилгаа явуулах


4.4 МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.4.1 Удирдлага, бүтэц зохион байгуулалт

Засгийн газрын 2014 оны 08-р сарын 28-ны өдрийн 280 тоот тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг үүсгэн байгуулсан.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь хөдөө аж ахуйн давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх ашгийн төлөө, төрийн болон хувийн өмчийн оролцоотой хувьцаат компани байна. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дүрэмд заасан зарласан хувьцааг гаргах, худалдах замаар хувийн өмчийн оролцоог нэмэгдүүлнэ. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК -ийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх хөрөнгийг улсын төсвөөс олгохоор хуульчилсан бөгөөд цаашид давхар даатгалын компани хувьцаа худалдан борлуулсны орлого, хуримтлагдсан ашиг, хуульд заасан бусад эх үүсвэрээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, зах зээлийн зарчмаар ажиллах юм

Хөдөө аж ахуйн давхар даатгал хувьцаат компани нь дараах бүтэцтэй байна.



Гүйцэтгэх захирал нь холбогдох хууль, журам болон компанийн дүрэмд заасан эрх үүрэгтэй.

Орлогч захирал нь давхар даатгалын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллана. Мөн сургалт сурталчилгааны ажлыг хариуцна.

Давхар даатгалын газар:

1. Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж даатгагч нарын давхар даатгуулах эрсдэлийн үнэлгээг /андеррайтинг/ хийж
2. Туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах, давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа шинжилгээ хийж, мэдээлэл боловсруулах
3. МИД-ын бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ, давхар даатгалын хураамж болон оролцогчийн хураамжийн тооцооллыг хийх
4. Орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй харилцаж ажиллах
5. Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлыг хийж хэрэгжүүлэх
6. Давхар даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой актуар тооцооллыг хийх
7. Төсөр хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах зэрэг ажлыг зохион явуулах, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тооцоолол хийх, батлуулах, зарцуулалтанд хяналт тавьж ажиллах
8. Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл

хамтын ажиллагааг хөгжүүлэх

9. Компанийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх
Давхар даатгалын газар дараахь орон тоотой байна. Үүнд:
 - Газрын дарга. Давхар даатгалын эрсдэлийн үнэлгээ хийж, туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулна.
 - Андеррайтер 1. МИД-ын бүтээгдэхүүн хариуцан ажиллах бөгөөд хөтөлбөрт оролцогч даатгалын компаниудтай харилцаж ажиллана. Дундын дансыг бүрдүүлэх, зохион байгуулах болон МИДОХ-ийн хураамж төвлөрүүлэх, эрсдэлийн тооцооллыг хийж гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн МИД-тай холбоотой тооцоолол болон дансны гүйлгээг хянаж ажиллана.
 - Андеррайтер 2. Газар тариалангийн даатгал хариуцсан ажилтан.
 - Андеррайтер 3. Бусад бүтээгдэхүүн хариуцсан ажилтан
 - Актуарч
 - Даатгалын шинжээч
 - Эрсдэлийн шинжээч
 - Гадаад хамтын ажиллагааны ажилтан
 - Төсөл, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар:

1. Компанийн сангийн хөрөнгийг холбогдох зохицуулалтын хүрээнд удирдах
2. Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг бүрдүүлж, нөхөн төлбөр тооцоолох, олгох асуудлыг удирдан зохион байгуулах
3. Нөхөн төлбөрийн тооцоолол, олгох асуудлыг хариуцах
4. Компанийн нөөц сан, эрсдэлийн сангийн зохион байгуулалтыг хариуцах
5. Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар дараахь орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга. Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- Хөрөнгө оруулалтын шинжээч. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нөөц сангууд болон Хамтын эрсдэлийн сангийн зохион байгуулалтыг хийх.
- Нөхөн төлбөрийн менежер. Давхар даатгалын гэрээний хүрээнд гарсан нөхөн төлбөрийн тооцооллыг хийх, давхар даатгуулагчид олгох.

Санхүү, удирдлагын газар:

1. Хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцан зохион байгуулах
2. Компанийн жилийн санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах, компанийн нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллах,

компаний санхүүгийн болон татварын тайланг хариуцан гаргах, санхүүгийн тайланг аудитоор баталгаажуулах, тайлагнах ажлыг хариуцан зохион байгуулах

3. Компанийн ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцан зохион байгуулах
4. Ажилчдын эрүүл мэнд, нийгмийн бодлогын асуудлыг хариуцаж удирдан зохион байгуулах
5. Компанийн үйл ажиллагааны тайлан гаргах, нэгтгэх,
6. Компанийн дотоод нэгжийн үйл ажиллагааг уялдуулах, бичиг хэргийн хөтлөлт, удирдлагад туслах ажил үүргийг гүйцэтгэх
7. Компанийн худалдан авалтын үйл ажиллагааг хариуцан ажиллах
8. Компанийн системийн зохицуулагчийн үүргийг хүлээж бүх компьютер, тоног төхөөрөмж, дотоод болон гадаад сүлжээг хэвийн ажиллагаатай байлгах, ажилтнуудын компьютерт зайлшгүй шаардлагатай болон хэрэгцээтэй бүртгэлийн, системийн болон хэрэглээний программ хангамжийг суулгаж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, засвар үйлчилгээг хийх, компанийн цахим хуудасны мэдээллийг байнга шинэчилж, хэвлэлийн эх бэлтгэлийн ажлыг хариуцан ажиллах
9. Компаний дүрэм, журмуудыг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, хуралд хэлэлцүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих
10. Төлөөлөн удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын гаргасан тогтоол, Гүйцэтгэх захирлын гаргасан тушаал, шийдвэрүүдийн эрх зүйн үндэслэлийг хянах

Санхүү, удирдлагын газар дараахь оронтоотой байна. Үүнд:

- Газрын дарга нь тайлан нэгтгэх, хүний нөөц, худалдан авалтын асуудлыг хариуцна.
- Нягтлан бодогч
- Захиргааны ажилтан
- Мэдээллийн технологийн ажилтан
- Жолооч
- Жолооч
- Үйлчлэгч

CRO:

Ерөнхий хуульч:

Компанийн ажилтнуудыг хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, шийдвэр албан бичгийн төслийг хянах, компанийг хууль хяналтын байгууллагад төлөөлөх зэргээр компанийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг хангах ажлыг цаг хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.

- Даатгал /давхар/-ын зах зээлийн зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал өгөх
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах, шинэчлэх, шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, зөвтгүүлэх, боловсруулах
- Компанийн бусад этгээдтэй байгуулах гэрээ, санамж бичгийн төсөл боловсруулах, эрх зүйн үндэслэлийг хянах, зөвтгүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэх
- Бүх албан бичгийн төслийг хянах, боловсруулах, зөвтгүүлэх, компанийн хэмжээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх

- Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хэрэг маргаантай асуудлаар хуулийн байгууллагад төлөөлөх
- Компанийн нэр бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүртгэх, хянах, хадгалах, АТГ-т тайлагнах, Авлигын эсрэг авах арга хэмжээг зохион байгуулах
- Компанийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлэх

4.4.2 Боловсон хүчин

Манай компани санхүү, даатгалын чиглэлээр гадаад, дотоодын их сургуулийг төгссөн, энэ чиглэлээр ажиллаж байсан, Банк санхүү, хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжлийн туршлага бүхий боловсон хүчинтэйгээр үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөн ажиллаж байна. МИДТ хэрэгжиж эхлэх үеэс даатгалын асуудал хариуцсан олон улсын зөвлөх авч ажиллаж байсан бөгөөд зөвлөх нь даатгалын бүтээгдэхүүн, хураамж, эрсдэлийн тооцоолол, давхар даатгалын асуудалд зөвлөх үйлчилгээ үзүүлж, МИД төслийн даатгал хариуцсан ажилтнуудад өөрийн туршлага, мэдлэгээ хуваалцаж байсан.

4.4.3 Техник тоног төхөөрөмж, программ хангамж

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь МИД төслийн төвд хэрэглэж байгаа сервер программ болон бусад холбогдох тоног төхөөрөмжийг ашиглана. Техник тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсаргав.

МИД төсөл хэрэгжиж эхэлсэн 2006 оноос хойш МИД-ын програм хангамжийг ашиглаж байгаа бөгөөд энэхүү програм нь жил бүр шинэчлэгдэн, улам боловсронгуй болж, одоогоор 21 аймаг, 7 даатгалын компанийн 110 салбар болон МИД-ын төсөл хэрэгжүүлэх нэгж онлайнаар холбогдон ашиглаж байна. Энэхүү програм хангамж нь 40 жилийн малын хорогдлын дүн мэдээнд үндэслэн эрсдэлийн шинжилгээ хийх, оролцогч даатгалын компаниуд бизнесээ төлөвлөх, борлуулалттай холбоотой бүхий л мэдээллийг бүртгэх, нөхөн төлбөрийн тооцоолол хийх зэрэг нүсэр нарийн тооцооллуудыг автоматжуулсан, олон жилийн малын хорогдлын мэдээллийн сан болон МИД-д даатгуулсан малчдын мэдээллийн санг үүсгэсэн програм хангамж юм.

Санхүүгийн программын хувьд сүүлийн үед ашиглагдаж байгаа программыг худалдан авч, ашиглахаар төлөвлөж байна.

4.5 САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.5.1 Тайлан баланс, үр дүнгийн тооцоо

МИДТ-ийн хүрээнд хэрэгжсэн МИД-ын бүтээгдэхүүний 2006-2014 оны борлуулалт, нөхөн төлбөр, давхар даатгал, санхүүгийн үйл ажиллагаа болон зах зээлийн судалгаанд үндэслэн ХАА-н Давхар Даатгал ХК-ийн санхүүгийн төлөвлөгөөг 2015-2017 он хүртэл боловсруулсан болно.

ХАА-н Давхар Даатгал ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх хөрөнгийг улсын төсвөөс олгохоор хуульчилсан. Иймд хувь нийлүүлсэн хөрөнгө 15,0 тэрбум төгрөг, Алдагдлаас хамгаалах сангийн 5,0 тэрбум төгрөгийг 2014 оны улсын төсвөөс санхүүжүүлсэн бөгөөд алдагдлаас хамгаалах сангийн үлдэгдэл 10,0 тэрбум төгрөгийг 2015, 2016 онуудын улсын төсвөөс санхүүжүүлнэ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн баланс, үр дүнгийн тайлангийн төсөөллийг дор үзүүлээ.

Хүснэгт 9. Хөрөнгө

	2014	2015	2016	2017
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,506,513,984	6,181,248,952	9,738,233,135	13,341,780,143
Богино хугацаат хөрөнгө оруулалт	15,161,114,324	22,000,000,000	26,800,000,000	26,800,000,000
Хадгаламж ЗГ-ын бонд АХС		5,000,000,000	9,800,000,000	9,800,000,000
Бусад: ЗГ-ын бонд	15,161,114,324	17,000,000,000	17,000,000,000	17,000,000,000
Эргэлтийн хөрөнгийн дүн	20,667,628,308	28,181,248,952	36,538,233,135	40,141,780,143
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө		210,000,000	210,000,000	210,000,000
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		210,000,000	210,000,000	210,000,000
Нийт хөрөнгийн дүн	20,667,628,308	28,391,248,952	36,748,233,135	40,351,780,143
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР	5,000,000,000	10,000,000,000	15,000,000,000	15,000,000,000
Богино хугацаат өр төлбөр	5,000,000,000	10,000,000,000	15,000,000,000	15,000,000,000
АХС	5,000,000,000	10,000,000,000	15,000,000,000	15,000,000,000
ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	15,667,628,308	18,391,248,952	21,748,233,135	25,351,780,143
Өмч: а) төрийн	15,000,000,000	15,210,000,000	15,210,000,000	15,210,000,000
Тайлангийн үеийн	667,628,308	2,513,620,644	3,356,984,183	3,603,547,008
Өмнөх үеийн		667,628,308	3,181,248,952	6,538,233,135
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	20,667,628,308	28,391,248,952	36,748,233,135	40,351,780,143

Хүснэгт 10. Үр дүн, тайлангийн төсөөлөл.

	2014	2015	2016	2017
Даатгалын хураамжын орлого	-	843,139,030	1,344,200,000	1,478,620,000
Давхар даатгалын хураамж /дээд, дунд түвшин/		843,139,030	1,344,200,000	1,478,620,000
Буцаасан даатгалын хураамж				
Хөрөнгө оруулалтын орлого	186,654,585	3,328,932,604	4,335,514,683	4,645,562,308
Бондын өгөөж	176,941,122	2,321,382,604	2,978,089,683	3,288,137,308
Хадгаламжын хүү	9,713,463	1,007,550,000	1,357,425,000	1,357,425,000
Давхар даатгалын комиссийн орлого				
НИЙТ ОРЛОГО	186,654,585	4,172,071,634	5,679,714,683	6,124,182,308
Үйл ажиллагааны зардал	76,000,000	1,557,695,990	2,186,988,000	2,384,892,800
Үндсэн болон нэмэгдэл цалин	54,640,000	661,240,000	900,000,000	950,000,000
Нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл шимтгэл	6,010,400	72,736,400	102,300,000	102,300,000

Албан томилолтын зардал	2,500,000	70,000,000	80,000,000	90,000,000
Тээвэр шатахууны зардал	3,349,600	13,464,000	18,000,000	25,000,000
Мэдээлэл Зар сурталчилгааны зардал	3,000,000	70,000,000	90,000,000	100,000,000
Шуудан, холбооны зардал	1,500,000	15,240,000	15,240,000	17,000,000
Бичиг хэрэгийн зардал		5,755,000	8,000,000	10,000,000
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		100,000,000	120,000,000	150,000,000
Олон улсын давхар даатгалын хураамж		374,241,190	591,448,000	650,592,800
Байрны түрээсийн төлбөр		81,344,400	90,000,000	95,000,000
Төлбөр хураамж бусад төлбөр		59,925,000	70,000,000	80,000,000
Гадаад зочид төлөөлөгчдийн зардал		20,000,000	22,000,000	25,000,000
Бусад зардал	5,000,000	13,750,000	80,000,000	90,000,000
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	110,654,585	2,614,375,644	3,492,726,683	3,739,289,508
Орлогын татварын зардал	971,346	100,755,000	135,742,500	135,742,500
Татварын дараах ашиг (алдагдал)	109,683,239	2,513,620,644	3,356,984,183	3,603,547,008

2.6 Эрсдэлийн шинжилгээ

2.6.1 Эрсдэлийн төрлүүд

Даатгалын эрсдэл

Малын даатгалын бүтээгдэхүүн нь эрсдэлийн хувьд өндөр бөгөөд нэг эсвэл хэд хэдэн жил дараалан зуд турхан болсон тохиолдолд даатгалын нөөц шавхагдах эрсдэлтэй юм. Иймд олон улсын давхар даатгалын зах зээлд тодорхой хэмжээний эрсдэлийг шилжүүлж хэвших хэрэгтэй.

Санхүүгийн болон зах зээлийн эрсдэл

ХАА-н Давхар даатгал ХК нь одоогоор МИД-ын бүтээгдэхүүнийг давхар даатгалд хамруулж байгаа тул санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны орлого хангалттай бус байх эрсдэлтэй юм. Мөн түүнчлэн малын даатгал нь сайн дурын даатгал бөгөөд малчдын хамрагдалтаас давхар даатгалын компанийн орлого шууд хамааралтай байгаа. МИД-ын бүтээгдэхүүн нь одоогоор төлөөлөгчийн сувгаар борлуулагдаж байгаа бөгөөд зардал өндөртэй тул борлуулалтын суваг нэмэгдүүлсэн байх шаардлагатай юм.

Хүний нөөцийн эрсдэл

Өнгөрсөн төслийн хугацаанд давхар даатгалын болон МИД төслийн ажиллах хүчний чадавхийг бэхжүүлсэн боловч шинэ бүтээгдэхүүний эрсдэл тооцоолол болон мэргэжлийн актуар тооцоолол хийх боловсон хүчин хангалттай биш байгаа. Гадаадын мэргэшсэн боловсон хүчинг олон улсын байгууллагын зардлаар ажиллуулах, дотоодын боловсон хүчнийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Шилжилтийн эрсдэл

МИД төслөөс “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК руу шилжихэд хүний нөөц, нөөц сан, хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотой хүндрэл гарч болзошгүй. Сангийн яам Дэлхийн банктэй ойлголцож шилжилтийн үеийн удирдлага, санхүүжилт, тайлан тооцоо, хяналтын орчинг

бүрдүүлэх, шаардлагатай бол холбогдох гэрээ хэлэлцээр, дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

2.6.2 Эрсдэлийг багасгах боломжууд

Компанийн хувьд нэн тэргүүнд давхар даатгалын эрсдэлээ тархаах үйл ажиллагаагаа цаашид тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор шинэ бүтээгдэхүүн гаргах судалгааг хийх шаардлагатай юм. Шинэ бүтээгдэхүүний хувьд газар тариалангийн бүтээгдэхүүн байх боломжтой бөгөөд ингэснээр МИД-ын давхар даатгалын эрсдэлийг тархаах, үйл ажиллагааны хувьд ХАА-н Давхар Даатгал ХК нь илүү тогтвортой болох юм.

Үр тариалангийн даатгалын тухай хуулийн 2-р бүлэгт тухайн жилийн усалгаагүй тариалсан үр тарианы нийт талбайн 20%, усалгаатай тариалсан үр тарианы болон баруун бүсийн усалгаагүй тариалсан үр тарианы нийт талбайн 10%-ийг албан журмаар даатгуулна гэж заасан байдаг. Энэхүү бүтээгдэхүүн нь дараах эрсдэлүүдээс хамгаална. Үүнд:

- Байгалийн эрсдэл: ган, үер, хүчтэй салхи, шуурга, мөндөр, хяруу, цас, цочир хүйтрэл зэрэг;
- Ургамал гоц хөнөөлт өвчин;
- Хөнөөлт шавж, мэрэгчид;
- Түймэр.

Төслийн хугацаанд МИД-ын борлуулалтыг даатгалын төлөөлөгчөөс гадна банк санхүүгийн байгууллага болон гар утсаар дамжуулан хийх талаар хэд хэдэн ажлуудыг зохион байгуулж байсан. Үүний үр дүнд 2015 оны борлуулалтын улирлаас эхлэн МИД-ыг Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан борлуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэ борлуулалтын суваг нь цаашид ХАА-н Давхар Даатгал ХК-ийн бусад бүтээгдэхүүнийг борлуулахад ашиглах боломжтой.

Төслийн хүрээнд өнгөрсөн хугацаанд тодорхой туршлага хуримтлуулж давхар даатгал, эрсдэл тооцоолол, актуар зэрэг чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн боловсон хүчний нөөцөд тулгуурлан дараа дараагийн ажилтнуудыг бэлтгэх, одоо байгаа хүмүүсийг улам чадавхжуулж ажиллах шаардлагатай юм.

2.7 Давхар даатгалын төлөвлөгөө

Төслийн хүрээнд өнгөрсөн 4 жилийн хугацаанд олон улсын давхар даатгагч нартай харилцаж хэд хэдэн олон улсын давхар даатгалын компаниудтай хамтын ажиллагаа тогтоосон билээ. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд энэхүү харилцаа холбоог үргэлжлүүлэн ажиллах хэрэгтэй бөгөөд өөр бусад давхар даатгагч нартай харилцаа холбоогоо тэлж ажиллах болно. Дараагийн 4 жилийн борлуулалтын төсөөллийг 2013 оны жилийн эцсийн малын тоо болон үнийг ашиглан гаргалаа.

Оролцогч даатгалын компанийн зүгээс жил бүр хамтын эрсдэлийн санд нийт хураамжийн 30%-ийг төвлөрүүлж, 40%-ийг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК шилжүүлнэ. Тухайн жилийн хураамжийн 45-50 хувь хүртэлх эрсдэлийг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК хариуцах бөгөөд эрсдэлийн тодорхой хэсгийг ОУ-ын давхар даатгалд шилжүүлэх болно. Даатгалын компанийн хувьд нийт хураамжийн 30% буюу үйл ажиллагааны зардал, Хамтын эрсдэлийн сангийн хүүгийн орлогоос ашиг олох боломжтой юм.

2.7.1 Давхар даатгалын эрсдэл хүлээх чадвар

МИД төслийн хүрээнд СЗХ-ны журамд заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан олон улсын давхар даатгалын компаниудтай харилцаж ирсэн бөгөөд цаашид ч энэхүү шалгуурыг үндэслэн олон улсын давхар даатгалын гэрээг байгуулах болно. Дунд болон дээд түвшний зарим эрсдэлийг дараах байдлаар олон улсын давхар даатгагч /цаашид ОУДД гэх/-д шилжүүлэхээр төлөвлөж байна.

Дунд түвшинд:

1. Алдагдал зогсоох

- Хохирлын харьцаа 45%-50% бол Хөдөө аж ахуйн давхар даатгал хувьцаат компани хариуцах

2. Эрсдэл хуваалцах

- Хохирлын харьцаа 50%-200% бол ОУДД-тай тэнцүү хуваалцах

3. Алдагдал зогсоох

- Хохирлын харьцаа 200%-иас дээш бол Хөдөө аж ахуйн давхар даатгал хувьцаат компани хариуцах

Дээд түвшинд:

Алдагдал зогсоох

1. Хохирлын хэмжээ даатгалын нийт үнэлгээний 0.04% хүртэл бол Хөдөө аж ахуйн давхар даатгал хувьцаат компани хариуцах

- Хохирол хэмжээ даатгалын нийт үнэлгээний 0.04%-4.08% хүртэл бол ОУДД хариуцах

2. Хохирлын хэмжээ даатгалын нийт үнэлгээний 4.08% давсан бол Хөдөө аж ахуйн давхар даатгал хувьцаат компани хариуцах

2016, 2017, 2018 онуудад сонгосон хувилбар /Хүснэгт 11/-ийн даатгалын тохиолдлууд үүсвэл нийт 11.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн 22 хувийг Хамтын эрсдэлийн сангаас, 31 хувийг дунд түвшний нөөц сангаас, 12 хувийг дээд түвшний нөөц сангаас, 35 хувийг ОУДД-аас санхүүжүүлнэ. Алдагдлаас хамгаалах сан /цаашид АХС гэх/- гаас нөхөн төлбөр олгох хэрэгцээ гарахгүй.

Хүснэгт 11. Сонгосон хувилбар 2000, 2001, 2002 оны зуд давтагдвал олгох нөхөн төлбөрийн санхүүжилт.

	2015	2016	2017	2018
МИД-ын нийт үнэлгээ	47,000,000,000	51,700,000,000	56,870,000,000	62,557,000,000
	4,00%	4,00%	4,00%	4,00%
Дунд түвшний хураамж	1,880,000,000	2,068,000,000	2,274,800,000	2,502,280,000

Дээд түвшний хураамж	470,000,000	517,000,000	568,700,000	625,570,000
Зудын шатлал 1, 2, 3, 4	1	2	2	2
Хор хөнөөл А, В, С, D		b	d	c
Дунд түвшний хорогдол	0.38%	3.97%	7.53%	5.40%
Дээд түвшний хорогдол	0.00%	0.33%	3.32%	0.94%
Дунд түвшний нөхөн төлбөр	112,111,652	1,865,900,000	3,893,010,000	3,070,980,000
Үүнээс: Хамтын эрсдэлийн сангаас	112,111,652	752,000,000	827,200,000	909,920,000
ОУ-ын давхар даатгагчаас		462,950,000	1,429,505,000	966,790,000
Дунд түвшний нөөц сангаас 1+2+3		650,950,000	1,636,305,000	1,194,270,000
Дээд түвшний нөхөн төлбөр		155,100,000	1,716,440,000	534,578,000
ОУ-ын давхар даатгагчаас			1,111,550,000	
Дээд түвшний нөөц сангаас 1+2		155,100,000	1,716,440,000	534,578,000
Алдагдлаас Хамгаалах Сангаас олгох				
Нийт нөхөн төлбөр	112,111,652	2,021,000,000	5,609,450,000	3,605,558,000
МИД-ын хохирлын харьцаа	5%	78%	197%	115%

Өөр нэг боломжит хувилбар бол ирэх 3 жилд 2010 оных шиг зуд тохиолдох хувилбар юм. Ийм тохиолдолд ч АХС-аас нөхөн төлбөр олгох хэрэгцээ гарахгүй.

Хүснэгт 12. Боломжит хувилбар 2009, 2010, 2011 оны зуд давтагдвал олгох нөхөн төлбөрийн санхүүжилт.

Дунд түвшний хураамж	1,880,000,000	2,068,000,000	2,274,800,000	2,502,280,000
Дээд түвшний хураамж	470,000,000	517,000,000	568,700,000	625,570,000
Зудын шатлал 1, 2, 3, 4	1	2	2	2
Хор хөнөөл А, В, С, D		a	c	a
Дунд түвшний хорогдол	0.11%	0.11%	10.60%	0.11%
Дээд түвшний хорогдол	0.00%	0.00%	8.11%	0.00%
Дунд түвшний нөхөн төлбөр	32,453,373	51,700,000	5,480,200,000	62,557,000
Үүнээс: Хамтын эрсдэлийн сангаас	32,453,373	51,700,000	827,200,000	62,557,000
ОУ-ын давхар даатгагчаас			1,551,000,000	
Дунд түвшний нөөц сангаас 1+2+3			3,102,000,000	
Дээд түвшний нөхөн төлбөр			4,192,870,000	
ОУ-ын давхар даатгагчаас			2,088,680,000	
Дээд түвшний нөөц сангаас 1+2			2,104,190,000	
Алдагдлаас Хамгаалах Сангаас олгох				

Нийт нөхөн төлбөр	32,453,373	51,700,000	9,673,070,000	62,557,000
МИД-ын хохирлын харьцаа	1%	2%	340%	2%

АХС-аас сангаас нөхөн төлбөр олгох хэрэгцээтэй байх хувилбарыг харуулах зорилгоор хэтрүүлсэн хувилбарын тооцооллыг Хүснэгт 12-д үзүүллээ. Хэтрүүлсэн хувилбарын хувьд нийт нөхөн төлбөрийн хэмжээ нь 32 тэрбум гаруй төгрөг байна. 2015-2017 онуудад хамрагдалт огцом нэмэгдэж, томоохон зуд тохиолдвол төсөөтэй нөлөө үзүүлж болзошгүй. АХСангийн журмын дагуу 5 хүртэл тэрбум төгрөгийг жилийн дотор буцаан дүүргэх хэрэгтэй бөгөөд Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д хангалттай эх үүсвэр байгааг Орлогын тайлан /Хүснэгт 12/-аас харж болно.

2.8 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө, эрсдэлээс хамгаалах болон алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх хөрөнгийг улсын төсвөөс нэг удаа олгохоор хуульчилсан байдаг. Үүний дагуу Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК дүрмийн сангийн 15 тэрбум, алдагдлаас хамгаалах сангийн 15 тэрбум, нийт 30 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр байгуулагдсан.

Малын индексжүүлсэн даатгалын сан нь хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын сан гэсэн төрөлтэй байх бөгөөд сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журмыг Санхүүгийн зохицуулах хороо болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байхаар хуульчилсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 242 тогтоолын дагуу 2014 оны 10-р сард дүрмийн сангийн 15.0 тэрбум төгрөгөөр 1 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-г хямдруулсан үнээр 14.7 тэрбум төгрөгөөр худалдан авч, хугацааны эцэст 2.3 тэрбум төгрөгийн бондын өгөөж авахаар байна.

Алдагдлаас хамгаалах сангийн 15 тэрбум төгрөг нь 2014-2016 онуудад 3 хуваагдан орж ирэх бөгөөд одоогийн байдлаар 7 тэрбум төгрөг компаний дансанд орж ирээд байна. Санхүүгийн Зохицуулах Хорооны 270 дугаар тогтоолын дагуу арилжааны 6 банкинд жилийн 14.4-16.5 хувийн хүүтэйгээр, 1 жилийн хугацаатайгаар хадгаламж хэлбэрээр байршуулсан.

Цаашид Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК хадгаламж болон бондын хүү, хувьцаа худалдан борлуулсны орлого, хуримтлагдсан ашиг, хөрөнгө оруулалтын бусад арга зам хуульд заасан бусад эх үүсвэрээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, зах зээлийн зарчмаар ажиллана.

Доорхи хүснэгтүүдээс бонд болон хадгаламжийн хүүгийн тооцоо болон 2016-2017 онуудад хөрөнгө оруулалтын төсөөллийг харууллаа.

Хүснэгт 13. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

	2014	2015	2015/2016	2016	2016/2017			2017/2018			тухайн онд ногдох цэвэр өгөөж
Төсвөөс өөрийн хөрөнгө	15,000,000,000	15,000,000,000	17,000,000,000	2,800,000,000	17,000,000,000	2,800,000,000	2,500,000,000	17,000,000,000	2,800,000,000	2,500,000,000	
Төсвөөс АХС 1											
Төлбөрийн зөрүү	348,611,880	348,611,880	0	0	0	0	0	0	0	0	
Төсвөөс АХС 2				2,800,000,000							
Үл хөдлөх											
Төсвөөс АХС 3							2,500,000,000				
Хямд хүү	16.07%	16.07%	15.05%	15.05%	15.05%	15.05%	15.05%	15.05%	15.05%	15.05%	
Эхлэх	10/13/2014	1/1/2015	10/13/2015	1/1/2016	10/13/2016	1/1/2017	4/1/2016	10/13/2017	1/1/2018	4/1/2017	
Дуусах	12/31/2014	10/12/2015	10/12/2016	12/31/2016	10/12/2017	12/31/2017	3/31/2017	10/12/2018	12/31/2018	3/31/2018	
Тоо	17,000	17,000	19,261	3,172	19,558	3,221	2,876	19,558	3,221	2,876	
Нэгж үнэ	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000	
Буцаан төлөгдөх	17,000,000,000	17,000,000,000	19,261,000,000	3,172,000,000	19,558,000,000	3,221,000,000	2,876,000,000	19,261,000,000	3,221,000,000	2,876,000,000	
Хямдруулсан дүн	14,651,388,120	14,651,388,120	17,000,000,000	2,800,000,000	17,000,000,000	2,800,000,000	2,500,000,000	17,000,000,000	2,800,000,000	2,500,000,000	
Өгөөж	516,178,435	1,832,433,445	2,261,000,000	372,000,000	2,558,000,000	421,000,000	376,000,000	2,261,000,000	421,000,000	376,000,000	
Хөрөнгө оруулалтын зардал	1,702,500		1,931,100	322,200	1,960,800	327,100	292,600	1,960,800	327,100	292,600	
Үр дүн	514,475,935	1,832,433,445	2,259,068,900	371,677,800	2,556,039,200	420,672,900	375,707,400	2,259,039,200	420,672,900	375,707,400	
2015		1,832,433,445	488,949,159								2,321,382,604
2016			1,770,119,741	371,677,800	553,224,923		283,067,219				2,978,089,683
2017					2,002,814,277	420,672,900	92,640,181	488,942,731		283,067,219	3,288,137,308

1. 12*7 хоног буюу 84 хоногтой үнэт цаасны хүү 14.674%

2. 28*7 хоног буюу 196 хоногтой үнэт цаасны хүү 15.02%

3. 52*7 хоног буюу 364 хоногтой үнэт цаасны хүү 15.473% -тай байна.

Дээрх 3 төрлийн бондын дундаж хүү 15,05%-аар дараагийн жилүүдэд авах бондын хүүг дунджаар тооцов.

Засгийн Газрын үнэт цаасны товч мэдээлэл

АХС 1-ийн 5 тэр бум төгрөгийг /25хувиар/ 4 банкинд хуваан байршуулсан

2015 он

Гэрээний дугаар	байршуулсан огноо	дуусах огноо	байршуулсан банк	мөнгөн дүн /мян.төг/	жилийн хүү /%/	жилд авах хүү /бодит/
	2015.01.14	2016.01.14	Төрийн банк	1,250,000	16.2%	182,250
№220-2015/01	2015.01.14	2016.01.14	ХХБ	1,250,000	14.4%	162,000
15/20/07	2015.01.14	2016.01.13	Хаан банк	1,250,000	16.5%	185,625
CIF№00917566	2015.01.14	2016.01.14	Хас банк	1,250,000	16.3%	183,375
						0
2014 оны алдагдлаас хамгаалах сан				5,000,000		713,250

АХС 2-ийн 2 тэр бум төгрөгийг 2 банкинд хуваан байршуулсан

2015 он

Гэрээний дугаар	байршуулсан огноо	дуусах огноо	байршуулсан банк	мөнгөн дүн /мян.төг/	жилийн хүү /%/	жилд авах хүү /бодит/
15/20/114	2015.04.17	2016.04.16	Хаан банк	1,000,000	16.5%	148,500
	2015.04.16	2016.04.15	Төрийн банк	1,000,000	16.2%	145,800
						294,300

АХС 3-ийн 2.5 тэр бум төгрөгийг 2 банкинд хуваан байршуулсан

2016 он

Гэрээний дугаар	байршуулсан огноо	дуусах огноо	байршуулсан банк	мөнгөн дүн /мян.төг/	жилийн хүү /%/	жилд авах хүү /бодит/
	2016.04.01	2017.03.31	Голомт банк	1,250,000	15.6%	175,500
	2016.04.01	2017.03.31	Капитал банк	1,250,000	15.5%	174,375
						349,875

Хадгаламжаас авах нийт хүүгийн хэмжээ

/мян.төг/

Байршуулсан банк	мөнгөн дүн /мян.төг/	жилийн хүү /%/	2015 онд авах хүү	2016 онд авах хүү	2017 онд авах хүү
Төрийн банк	1,250,000	16.2%	182,250	182,250	182,250
ХХБ	1,250,000	14.4%	162,000	162,000	162,000
Хаан банк	1,250,000	16.5%	185,625	185,625	185,625
Хас банк	1,250,000	16.3%	183,375	183,375	183,375
Хаан банк	1,000,000	16.5%	148,500	148,500	148,500
Төрийн банк	1,000,000	16.2%	145,800	145,800	145,800
Банк сонгох	1,250,000	15.6%		175,500	175,500
Банк сонгох	1,250,000	15.5%		174,375	174,375
НИЙТ			1,007,550	1,357,425	1,357,425

ГУРАВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН САНАЛ

3.1 Олон улсын Банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, олон улсын зөвлөх, санхүүжилт авах чиглэлээр ажиллах

- Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27.1 дэх заалтанд “ХААДД” ХК бие даасан даатгалын нөөц сантай байх ба хуулийн 27.2-д Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар зохицуулахаар тусгасан байдаг.

Санхүүгийн зохицуулах хороо нөөц санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах талаарх журмын төслийг боловсруулж байгаа болно. Журмын төслийн эцэслэн батлагдахаас өмнө “ХААДД” ХК-ийг олон улсын банк санхүү, даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах эрх олгож өгөх талаарх хүсэлтийг хүргүүлж, саналаа солилцож байна. Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос гадаадын банк санхүү, даатгалын байгууллагуудтай хамтран ажиллахыг дэмжиж, зохих зөвшөөрлийг олговол олон улсын зэх зээлээс санхүүжилт, эх үүсвэр мөнгө босгох, мөн олон улсын давхар даатгал болон санхүүгийн өндөр мэдлэг, туршлага бүхий зөвлөх авч ажиллах төлөвлөгөөтэй байна.

- Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Хөгжлийн зээлийн хэлэлцээр”, “Нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр”, “Хөгжлийн зээлийн шинэчилсэн хэлэлцээр”-ийн дагуу Малын индексжүүлсэн даатгал төслийг 2005 оноос эхлэн хэрэгжүүлсэн.

Дээрх хэлэлцээрийн дагуу Малын индексжүүлсэн даатгал төсөл нь 2016 онд дуусгавар болохоор заасан байдаг. Өнөөдрийн байдлаар даатгалын хураамжийн хуритмлалын үлдэгдэл нь 2.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд Дэлхийн банк болон Монгол Улсын засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрт өөрчлөлт орсны дараа хуритмлалын үлдэгдэл болон төслийн дата сервэрийг “ХААДД” ХК-ийн мэдэлд шилжүүлэх болно.

Монгол Улсын засгийн газар болон Дэлхийн банк хооронд байгуулсан хэлэлцээрт өөрчлөлт оруулах зорилгоор Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны а/99 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийнхэн Дэлхийн банкны зөвлөснөөр “Шилжүүлэлтийн төлөвлөө”-г боловсруулах асуудлыг хариуцан ажиллаж байна.

3.2 Компанийг цаашид үндэсний давхар даатгалын корпораци болоход суурь болох.

Улсын Их Хурлын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн Эдийн засгийн хүндэрлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай тогтоолын 11 дүгээр зүйлийн 3 дугаар заалтад Үндэсний давхар даатгалын корпораци үүсгэн байгуулна гэж заасан байдаг.

Аливаа улс орны санхүүгийн салбарын хөгжил ба эдийн засгийн хөгжил нь хоорондоо маш тодорхой уялдаа холбоотой байдаг. 2007 онд НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурлаас (НҮБХХБХ) даатгалын сектор бол санхүүгийн салбарын гол тулгуурын нэг бөгөөд тухайн улсын эдийн засгийн дэд бүтцийн хөгжил, худалдаа арилжаанд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг онцолсон. Дэд бүтцийн хувьд авч үзэхэд, сайн хөгжсөн даатгалын сектор нь хөрөнгийн зохистой

хуваарилалтыг бүрдүүлж, мөнгийг эргэлтэнд оруулан хадгаламж руу чиглүүлж, худалдаа арилжаа, бизнес эрхлэлтийг дэмжиж, ард иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлдэг. Бизнесийн өнцгөөс харвал даатгалын компаниуд нь дотоодын санхүүгийн салбарыг хөгжүүлж, олон улсын хөрөнгийн зах зээлд байр сууриа эзэлж, хөрөнгө оруулагчдад санхүүгийн чадавхийн талаар итгэл төрүүлдэг. Иймээс эрсдэлийн удирдлага болон давхар даатгалын тогтолцоо нь санхүүгийн салбарын чухал хэсэгт тооцогддог. Хөгжиж буй орнуудын хувьд давхар даатгалын баталгаат байдал болон эрсдэл тархаан байршуулах хэрэгцээ хоёрын зөв тэнцвэрийг олох нь чухал байдаг билээ. Аливаа улс орны үндэсний давхар даатгагчийг үүсгэн байгуулах гол шалтгаан нь эдийн засгийн сэдэлтэй буюу давхар даатгалын хураамжийг улсдаа үлдээхэд оршдог. Хөгжиж буй орнуудын гадагшаа урсгалтай валют жилээс жилд өсөн нэмэгддэг нь даатгалын компаниуд орлогынхоо нэлээд хувийг гадаад руу давхар даатгалын хураамж хэлбэрээр шилжүүлж, Монгол улстай адил эргээд багахан хувийг нөхөн төлбөр байдлаар авдагтай холбоотой.

Хэдийгээр Монголын даатгалын салбар өндөр өсөлттэй байгаа боловч санхүүгийн зах зээлд эзлэх хувь нь 1 хувь хүрэхгүй хэмжээтэй байгаа юм. Монгол улсын даатгалын компаниуд 2013 онд 25.9 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг гадаадын давхар даатгалд төлсөн байгаа нь нийт хураамжийн 27.6%-тай тэнцүү байгаа юм. Үүнээс 460 орчим сая төгрөг нь ХАА-н давхар даатгалын хураамжинд төлсөн байна. 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 31.6 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн дүнтэй гарсан байна. Үүнээс үзэхэд манай улс Үндэсний давхар даатгалын компани байгуулах шаардлагатай байгаа бөгөөд даатгалын салбарын эзлэх хувь хэмжээ бага, хөгжиж буй орны хувьд Давхар Даатгалын нэг компани байх нь зохимжтой байна.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагаа харьцангуй бүрэн тогтворжиж орон даяар нийт аймаг, сумдуудад борлуулалтын үйл ажиллагаа явагдаж эхлээд байгаа билээ. Мөн Малын индексжүүлсэн даатгалын хууль батлагдан гарснаар СЗХ-ноос үндэсний анхны давхар даатгалын компани болох “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалт нь Үндэсний давхар даатгалын корпорацийн суурь болоход хялбар харагдаж байна. Энэ бүхнээс үзэхэд тус компани нь зөвхөн Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа явуулах бус компанийн цар хүрээг өргөжүүлэн бусад салбарын даатгалын тогтолцоог нэвтрүүлж цаашид уг компанийн үйл ажиллагаанд суурь болгон Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах бүрэн боломжтойгоос гадна Засгийн газраас баримталж буй бүх нийтээр эдийн засгийн хэмнэлтэд шилжих шийдвэртэй уялдаж байна.